

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-38

1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	6-28
2.“Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 3.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	28-34
3.Хууль, тогтоолын төслийн эцсийн найруулга сонсох	34
4.Хууль, тогтоолын төслийг эцэслэн батлах	34-38

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 21-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Р.Батболд, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Б.Бейсен, Э.Болормаа, С.Бямбацогт, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Х.Жангабыл, Б.Жаргалан, Б.Заяабал, Ц.Мөнхбат, Н.Наранбаатар, С.Одонтуяа, О.Саранчулуун, Р.Сэддорж, Б.Уянга, Б.Хэрлэн, С.Цэнгүүн, Ж.Чинбүрэн, Ж.Энхбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Ц.Даваасүрэн, Э.Одбаяр, У.Отгонбаяр, Б.Түвшин;

Чөлөөтэй: Б.Батцэцэг, Б.Жавхлан, Л.Оюун-Эрдэнэ, С.Эрдэнэбат;

Хоцорсон: О.Алтангэрэл- 03 минут, Н.Алтаншагай- 21 минут, С.Амарсайхан- 1 цаг 12 минут, Ц.Баатархүү- 03 минут, М.Бадамсүрэн- 01 минут, Д.Батбаяр- 01 минут, Д.Батлут- 04 минут, Х.Булгантуяа- 01 минут, Д.Ганбат- 03 минут, Л.Гантөмөр- 07 минут, М.Ганхүлэг- 04 минут, Д.Жаргалсайхан- 08 минут, С.Лүндэг- 06 минут, З.Мэндсайхан- 14 минут, П.Наранбаяр- 13 минут, М.Нарантуяа-Нара- 09 минут, Б.Пунсалмаа- 14 минут, Л.Соронзонболд- 01 минут, Б.Тулга- 1 цаг 34 минут, А.Ундраа- 18 минут, Ч.Ундрам- 13 минут, Н.Учрал-1 цаг 12 минут, Б.Чойжилсүрэн- 21 минут, Р.Эрдэнэбүрэн- 1 цаг 12 минут.

Нэг.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Усны газрын дарга З.Батбаяр, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ, “Мон-Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын

ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, С.Ганбаатар, Ө.Шижир, Д.Ганмаа, Ц.Сандаг-Очир, Б.Батбаатар, А.Ундраа нарын тавьсан асуултад “Мон-Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Пүрэвдорж, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, “Мон-Атом” ХХК-ийн мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Н.Номтойбаяр нар хариулж, тайлбар хийв.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсгийн “энэ хуулийн 34.6-д заасан журмын дагуу тооцож, төрийн дансанд байршуулна.” гэснийг “олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэл, эс үгүй бол Монголбанк дахь валютын тусгай дансанд байршуулах бөгөөд гагцхүү зориулалтын дагуу ашиглана.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ж.Ганбаатар, Д.Бум-Очир, Г.Ганбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Д.Батбаяр, А.Ундраа, З.Мэндсайхан, Г.Тэмүүлэн нарын санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 93 гишүүнээс 66 гишүүн дэмжиж, 71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлуулах эсэх талаар Улсын Их Хурлын гишүүдээс асууж, олонхын саналаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулахаар тогтов./11:19/

Хоёр. “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	32
Бүгд:	93

65.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Туваан нарын саналыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 93 гишүүнээс 64 гишүүн дэмжиж, 68.8 хувиар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:40/

Уг асуудлыг 11 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Баталсан тогтоолын эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:41/

Уг асуудлыг 11 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Д.Амарбаясгалан: 1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 24
Бүгд: 94

74.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 30
Бүгд: 94

68.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Д.Энхтүвшин, Ж.Баясгалан, Л.Мөнхбаясгалан, Ж.Батсуурь нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 94 гишүүнээс 69 гишүүн дэмжиж, 73.4 хувийн саналаар хууль батлагдлаа.

3.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 30
Бүгд: 94

68.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Алтаншагай, Д.Батбаяр, Б.Найдалаа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 94 гишүүнээс 69 гишүүн дэмжиж, 73.4 хувийн саналаар хууль батлагдлаа.

4.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 30
Бүгд: 94

68.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, Р.Эрдэнэбүрэн, Н.Номтойбаяр, Т.Доржханд нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 94 гишүүнээс 69 гишүүн дэмжиж, 73.4 хувийн саналаар батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 53 минут үргэлжилж, 126 гишүүнээс 94 гишүүн хүрэлцэн ирж, 74.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж, өглөөний мэнд хүргэе. Нийт 69 гишүүн ирж, ирц 54,8 хувьтай болсон байна.

11 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

2 дугаарт, “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

3 дугаарт, “Монгол Улсын Их Хурлын 2024-өөс 28 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 14, 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн болно.

Тус Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбат хууль хэрэгжиж эхлээд ямар хугацаанд үр дүн гарах, Рона групп нь манай улсад үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ хамгийн сүүлийн үеийн техник, технологи ашиглах талаар баталгаа гаргуулах, олборлох ураныг энх тайвны зорилгоор ашиглах талаар гэрээндээ тусгах, олборлосон тодорхой хувийг орлуулах эрхтэй байх, Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл дээрх хуулийн төсөл болон цаашид хийх гэрээ, хэлэлцээрийн талаар иргэд олон нийтийг мэдээллээр хангах, шинжлэх ухааны ойлголтуудыг тодорхой ойлгомжтой хүргэхэд анхаарах талаар асуулт асууж, хариулт авлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед 1 зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж, дээрх гүйцээн боловсруулсан 1 зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрөөтэй саналуудыг Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн холбогдох хэсэг, зүйл, заалтад нэмж тусгаснаас гадна төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, хууль зүйн техникийн талаас хянаж, зохих засвар өөрчлөлтийг хийсэн эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга, Байнгын хорооны дэмжсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Цэвэгдоржийн Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Гончигсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зэнэмидэрийн Батбаяр Усны газрын дарга,

Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Гун-Аажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил СЗХ-ны Хууль, эрх зүйн газрын дарга, Батмөнхийн Агиймаа ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер, Доржбалын Далайжаргал Мон-Атом компанийн гүйцэтгэх захирал, Дашдаваагийн Сугарсүрэн Мон-Атом компанийн Захиргааны удирдлагын албаны дарга, Амарсайханы Алтанхундага Мон-Атом компанийн Геологи, уул уурхайн албаны ахлах менежер, Норовын Тэгшбаяр Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нийт 10 гишүүний нэр ирсэн байгаа. Ирсэн ирцийн дарааллаар Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Өглөөний мэнд. Цөмийн энергийн тухай хуулийн хэлэлцүүлэг үндсэндээ ингээд эцсийн шатдаа орж байна. Ажлын хэсгээс нэг 2 асуулт байна. Ажлын хэсэг арай орж ирээгүй байгаа юм уу, тийм ээ.

Байгаль орчны үнэлгээний хууль байдаг. Тэгээд үүнтэй холбоотой төлөв байдлын үнэлгээ, байгаль орчин, нийгмийн үнэлгээг яаж хийх талаар хуулийн өөрчлөлт нэмэлтээр орсон зүйл бий юу гэдэг 1 дүгээр асуулт байна. Үүнийг яагаад асууж байгаа вэ гэхээр бид чинь Эрдэнэбүрэнгийн УЦС-ын нөлөөллийн бүсэд нөхөн олговор олгох, олгосон асуудал маш их хэл ам дэгдээсэн. Тэр хавцалд чинь бараг 1000-аад айл болчихсон уу, яасан. Улаанбадрах сум болон энэ Зүүнбаян баг яг энэ Зөөвч-Овоо үндсэн ордод их ойрхон байдаг. Үүнтэй холбоотой энэ багийн айл өрхүүдэд нөхөн олговор яаж олгогдох вэ гэдэг асуудал байна. Энэ тусдаа орж байгаа юу, эсвэл нөгөө орон нутагт жил болгон олгогдох нөгөө сая доллароос олгох гээд байна уу? Үүнийг тодорхой хариулт авмаар байна. Орон нутгийн хүний хувьд.

2-т нь, Орос, Украйны дайн болоод бараг 3 жил болж байна. Энэ дайны үндсэн шалтгаан бол мөнгө, байгалийн баялгийн төлөөх тэмцэл шүү дээ. Зүгээр харахад геополитик янз бүрийн юм яриад байгаа боловч. Байгалийн баялгаараа Европт хамгийн баян орон болох Украйны газрын ховор элементийн төлөө л тулалдаж байгаа юм. Үүнийг нь сая АНУ-ын гадаад бодлогын стратегич, ахмад сенатор Грахм их тодорхой ярьсан байна лээ шүү дээ. Газрын ховор элементийн үнэлгээ нь бүр Украйныхыг 2-7 триллион доллар гээд хэлчихсэн. Манайх урьд нь Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газар гээд Ерөнхий сайдынхаа шууд харьяа дотор, харьяа доор байсан. Ер нь манай улсын цаашдаа гартаа барих, ялангуяа манайх шиг энэ жижиг улсад бол гартаа барих гол зэвсэг бол газрын ховор элемент энэ уран болох нь ээ. Үүнтэй холбоотойгоор энэ Цөмийн энергийн газар гэж хуучин байсан энэ газраа дахин сэргээж, Ерөнхий сайдынхаа хяналт удирдлага гэдэг юм уу, энэ доор ер нь энэ бүтцээ арай эргүүлж бодох юм биш үү? Яг ингээд л Уул уурхай, эрдэс баялгийн яамандаа юм уу, энэ хуучин байсан энэ бүтэц чинь хэр зохистой байсан бэ? Нөхцөл байдал арай өөр болоод байна гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Мон-Атом компанийн захирал Далайжаргал ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Д.Далайжаргал: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2006 оноос эхлээд нийгмийн хариуцлагын хүрээнд нийтдээ 9 тэрбум төгрөгийг орон нутагт зарцуулчихсан байгаа. Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Гэрээг 2, 2 жилээр байгуулдаг. Хамтын ажиллагааны гэрээний дагуу тэрбум төгрөгийг орон нутагт зарцуулдаг байгаа.

Улаанбадрах сум буюу Улаанбадрах суманд 700 сая. Таны хэлж байгаа уурхайтай байгаа аймаг Зүүнбаян суманд 300 сая төгрөгийг жил болгон зарцуулаад явж байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон. Нэмэлт хариулт өгье.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Мөнхтогтох.

Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.4-д заасны дагуу байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг ААНБ үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой зардлыг тухайн жилийнхээ төсөвтөө байршуулна.

Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.9-д заасны дагуу төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтууд явж байгаа. Эдгээр эрх зүйн зохицуулалт нь одоо байгаа хуулиараа хүчин төгөлдөр мөрдөгдөхөд хангалттай байгаа. Мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Байгаль орчны багц хуулиудыг өөрчлөх шинэчлэлийн ажил явагдаж байгаа. Энэ дээр холбогдох өөрчлөлтүүд нь бие даагаад ороод явж байгаа.

Д.Амарбаясгалан: Тодруулах юм уу. Гомбын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Г.Ганбаатар: 2 дахь асуулт дээр хэн ч хариулсангүй. Ерөнхийдөө газрын ховор элемент болоод энэ уран бол манай улсын гартаа барих гол хөзөр болох нь. Тэгээд үүнийгээ хуучин байсан бүтэц буюу ялангуяа энэ одоо байгаа бүтэц чинь хэр зохистой вэ гэдэг асуулт. Хуучин бол яг Ерөнхий сайдынхаа удирдлага доор байсан шүү дээ.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье. Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Яалт ч үгүй энэ цацраг идэвхт ашигт малтмал буюу энэ ураны асуудал, дээрээс нь энэ газрын ховор элементийн асуудал бол стратегийн ордод ордог стратегийн бүтээгдэхүүнүүд байгаа. Тэгэхээр дэлхий нийтэд ч гэсэн энэ түвшинд ойлгож, анхаарал хандуулж ирсэн. Эдгээр бүтээгдэхүүнүүд бол бас геополитикийн хувьд тоглох ийм багаж хэрэгсэл болж өгдөг ийм чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн.

Манай орны хувьд Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулдаг. Дээрээс нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар эдгээр элементүүдийг Засгийн газар дээр лиценз олгох, шилжүүлэх асуудлыг нь хариуцаад явж байгаа. Мөн зарим Их Хурлын

гишүүдийн санаачилгаар удахгүй орж ирэх Ашигт малтмалын тухай хууль дээр эдгээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Маргарет Тэтчер нэг удаа хэлсэн байдаг юм. Би асуудал ярихаар өөдөөс миний хувь хүн рүү ярих юм. Би асуудал дээрээ ялчихсан юм байна гэдэг шиг би асуулт л асууж байгаа. Би асуудлыг л ярьж байгаа. Ямар ч хувь хүн нэг ч яриагүй. Тэгэхээр би асуултаа асууя.

Би 2 асуулт асууна. Энэ эцсийн хэлэлцүүлэг дээр. 2.5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт гэдэг дээр 5.2, 5.3-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах өөрчлөх ийм л хууль орж ирж байгаа шүү дээ. 5.2, 5.3 дээр юу гэж заасан бэ гэвэл улс өөрийн хөрөнгөөр хайгуул хийсэн бол 51 хувийг эзэмшинэ, үнэ төлбөргүйгээр гэдэг нь үнэ төлбөргүй гэсэн үг биш. Тэр баялгийг газар доор байгаа баялгаа үнэлж байна гэсэн үг. Түүнийг 51 хувьтай хэмжээгээр үнэлнэ. Тэрэндээ нэмж мөнгө төлөхгүй шүү л гэсэн санаа. Өөрсдөө бид ашигт малтмалын хайгуул хийгээгүй бол тэр тухайн компанийн 34 хувийг баялгаараа бид авна шүү гэж хэлсэн үг. Үүнийг бид өөрчилж Улсын Их Хурлаас мэдлийн Цөмийн энергийн комисс гэдэг хэлэлцээр байгуулах гэж байгаа хүмүүст л өгөх гэж байгаа. Тэр нь яам яамнаас нэг хэдэн хүн орсон бүлэг комисс эзэн биегүй.

Тэгэхээр миний асуулт 5.2, 5.3 буюу 34 хувь, 51 хувийг рояалти руу хөрвүүлж шилжүүлнэ гэж байгаа. Та нар эдийн засгийн тооцоог хэлж өгөөч ээ? Би хоёр 7 хоног асууж байна. Би өөрийнхөө арифметик тооцоог хэлж байгаа. Энэ 34 хувь бол 23,8 хувийн рояалтитай ойролцоо тэнцүү байна. Нөгөөдөх нь 35,7 хувьтай тэнцүү байна. Та нар энэ дээр тоо бодсон уу?

2 дугаар асуулт. 34 хувиа та нар ингээд буулгаад өгчихлөө, гаднын компанид. Дараа нь энэ үнэ цэнтэй зүйл. Энэ их чухал зүйл. 34 хувьтай тэнцэх хэмжээний шар нунтгаа өөрсдөө буцааж худалдаж авах эсвэл өөрөө дураараа хэн нэгэнд худалдах эрх нь байгаа юу? Энэ чинь ховрын бараа шүү дээ. Картын бараа, үнэ цэн гэхээс илүү ховор чухал. Энэ 2 асуултад хариулж өгөөч. Үндсэндээ нэг 3 тэрбум гэж анх ярьж байсан. Одоо 5 тэрбум долларын ашигтай гэж байгаа. Бидний нүүрсээрээ олдог мөнгөний нэг жилд олдог мөнгөний хаана ч хүрэхгүй мөнгийг л бид ярьж байгаа юм шүү дээ. 34 жил ухна.

2 дугаар асуулт. Энэ Байгаль орчны яамныханд хариуцлага тооцно. Энэ дээр та нар 215 мянган тонн хүхрийн хүчил буюу өдөрт 15 вагон хүхрийн хүчлийг тэр газар луу шахаж оруулна. Тэр дотор ямар ч труба байхгүй, шууд шахна. Тэнд ямар ч паар байхгүй. Тэгэхээр тэр 15 вагон өдөр болгон шахаж байгаа тэр байгаль дэлхийн тэр аюулгүй байдал дээр та нар дүгнэлт гаргасан уу? Хүхрийн хүчлийн үйлдвэр барих уу? Та нар 50 сая долларыг жилдээ хүхрийн хүчилд зориулна. Үүнийг л Нарантуул шиг гаднаас авна. Монголчууд үүнийг авч болох уу? 5 Зэсийн хайлуулах үйлдвэр баригдах гэж байгаа шүү дээ. Энэ тухай хариулт өгөөч. Энэ асуулт бол 34.3 дугаар зүйл дээр асууж байгаа юм шүү. 750 тонн аюултай хог хаягдлыг бид нар эндээс гаргаж авна. Хог хаягдлын үйлдвэр байгаа юу. Аюултай хог хаягдлын үйлдвэр байгаа юу, байхгүй. Байгаа гэж худлаа ярьсан. Хэзээ барих вэ. Энэ ажлын хэсэг дотроо байгуулсан уу, та нар. Энэ эрх зүйн орчин дээрээ бүрдүүлсэн үү. Ийм 2 асуултыг тодруулж асууя.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгээд энэ хэлэлцүүлгийн шатад Ганбаатар гишүүний асуусан асуултуудыг бүгдийг нь протоколд тэмдэглэж авч байгаа. Тэгээд цаашдын хөрөнгө оруулалтын гэрээн дээр энэ асуудлуудыг нэмж ярина гэдгийг хэлье.

Бид бүхэн энэ, энэ хууль бол та яг зөв хэлж байгаа. Юу гэхээр 34 хувийн хувьцааг үнэ төлбөргүй хувьцааг юу тусгай АМНАТ-аар солих энэ вариантыг боломжийг бий болгож өгч байгаа хуулийг л энэ цөмийн энергийн хуульд тусгаж өгч байгаа юм. Тэр нь эргээд яг 34 хувийг ор байхгүй болгоод заавал үүгээр явна гэсэн агуулга биш гэдгийг хэлье. Яагаад энэ боломжийг нээж өгч байгаа вэ гэхээр бид бүхэн 19 оны Үндсэн хууль дээрээ энэ Үндсэн хуулийн 6.2 дээрээ энэ уул уурхайн баялаг, тэр дундаа энэ стратегийн ордоос олж байгаа орлогын дийлэнх хэсэг нь буюу 50 дээр +1 хэсэг нь Монгол Улсад үлдэхээр байх ёстой гэдэг энэ хуулийг баталсан учраас энд зохицуулахын тулд бид нар энэ алхмыг хийж байгаа гэдгийг хэлье.

Бид нар 34 хувийг эзэмшээд өмнө нь хийсэн гэрээ хэлцлүүд олон улсын өмнөх нэг гэрээ байгаа. Түүнийг нэрийг нь хэлээд яах вэ. Тэгэхээр түүн дээр бид нар өнөөдөр шүүмжлэлтэй янз бүрийн байдлаар энэ асуудалд ханддаг. Тэгэхээр энэ 34 хувийг солиод, давуу эрхийн 10 хувийн хувьцаатай бид нар үлдэнэ. Тэгэхээр энэ давуу эрхийн хувьцаа бол бид нар энэ ноогдол ашгаа хамгийн түрүүнд авах ийм давуу эрхтэй. Тэгээд мөн 10 хувьтайгаа үлдэж байгаа асуудал гэдгийг энд хэлье.

Тэгээд дээрээс нь бусад бүх төрлийн өмнөх бүх хэлэлцүүлгүүдээр ярьсан учраас бүх төрлийн татвар, АМНАТ зэргүүдийг бүгдийг нь аваад энэ 50 дээр +1 хувь хангагдах юм гэдэг ийм байдлаар асуудалд хандаж байгаа гэдгийг хэлье.

Шар нунтгаа бид нар борлуулна. Борлуулаад, борлуулсан үнийн дүнгээс шууд энд ноогдох АМНАТ-ын татвараа авна. Хэрвээ шар нунтгаа авъя гэж үзэх юм бол бид нар давуу эрхийн 10 хувийн хувьцаандаа тэнцүү хэмжээний шар нунтгийг авч болох байх, авч болно гэдгийг хэлье.

Хүхрийн хүчил дээр бид нар зэс хайлуулах үйлдвэр барьсан тохиолдолд эндээс хүхрийн исэл гарч ирнэ. Энэ хүхрийн ислээр бид нар элементийн хүхэр үйлдвэрлэх юм уу эс үгүй бол хүхрийн хүчил үйлдвэрлэх үү гэдэг ийм сонголт гарч ирнэ. Монголд тэртээ тэргүй Эрдэнэтэд нуруулдан уусгах, Оюутолгой дээр нуруулдан уусгах технологийг удахгүй ашиглана.

Дээрээс нь энэ Ронагийн энэ далд уурхай дээр, далд уусган олборлолт дээр бид нар хүхрийн хүчлийг хэрэглэнэ. Тэгэхээр бид нар өөрсдөө зэс хайлуулах үйлдвэрээ дагуулаад хүхрийн хүчлийн үйлдвэртэй болно. Таны хэлсэнчлэн хүхрийн хүчлийн бид нар валют зарж, импортоор авахгүй, дотооддоо үйлдвэрлэж энэ дотоодынхоо хэрэгцээг хангана гэдгийг хэлье.

Тэр хаягдлын үйлдвэр дээр манай ажлын хэсэг нэмээд хариулчих.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэмж хариулна.

Б.Пүрэвдорж: Би тэгэхээр Ганбаатар гишүүний энэ Оюутолгойн гэрээтэй холбоотойгоор шүүмжлэлээ хэлдгийг мэднэ. Тэгэхээр ер нь бид нар яг энэ томоохон гэрээн дээр 2 том компанитай гэрээ байгуулах, нэг нь байгуулсан. Нөгөөдөх нь байгуулах гээд зорьж байна. Олон олон компаниуд байгаа. Тэгэхээр энэ дээр 200, 300 жилийн түүхтэй гэрээний эрх зүйгээр явчихсан тэр компаниудтай гучаадхан жилийн гэрээний эрх зүйтэй энэ Монгол Улс тодорхой хэмжээгээр яг энэ гэрээн дээрээ алдах ийм тохиолдлууд байсан гэдгийг хэлье.

Тэгэхээр Оюутолгойн гэрээг би тийм алдаатай гэж үздэггүй. Тэгэхдээ юу вэ гэх дээр тэндээс 5 хувийг нь АМНАТ авч байгаа. Түүгээр өнөөдрийн байдлаар 13 жилийн туршид 800 орчим сая долларын АМНАТ авсан байна. Дээрээс нь жишээ нь ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж микрофон өгье, гүйцээж хариулъя.

Б.Пүрэвдорж: Оюутолгой гэхэд энэ жил 1 их наяд 360 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна. Бусад татваруудаараа. Дээрээс нь Оюутолгойн энэ эдийн засагт оруулж байгаа энэ бараа, үйлчилгээ явуулж байгаа тэр хувийн хэвшлийн компаниуд энэ тэр дээр асар их хувь нэмэр оруулж байгаа гэдгийг хэлье. Гэлээ ч бид нар өнөөдрийг хүртэл 34 хувийнхаа ногдол ашгийг 48 он хүртэл авахаар ингээд хойшлоод байж байгаа. Тэгэхээр бид нар энэ дээрээ тодорхой хэмжээний зөв алхам хийе. Өөрөөр хэлбэл АМНАТ-аар орлуулъя. Энэ АМНАТ нь шууд бүтээгдэхүүнээ гаргангуут бид нар шууд тоолуур тоолоод эхлэх энэ арга хэмжээг авъя гэж үзэж байгаа. Үүний хүрээнд суурь АМНАТ 5 хувь, тусгай АМНАТ 5 хувь, ААНОАТ 25 хувь, дээрээс нь 13 татвар, хураамж, шимтгэл, төлбөр авна. Тэгээд энэ нөхцөл байдлаараа энэ АМНАТ-аар орлуулсан нь ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт. Манлайжав дарга Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Ганбаатар гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Манлайжав Цөмийн энергийн комисс.

Төслийн үйл ажиллагаанаас нийтдээ 2 зуугаад 50 тонн цацраг идэвхт хаягдал үүсэх юм байгаа юм. Тэгэхээр бид нар олон улсын болон Монгол Улсын үндэсний дотоод дүрэм журмын дагуу энэ хаягдлыг хаягдлын менежмент хийх үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын гэрээ болон бусад дүрмүүд дээр тусгасан. Монгол Улсын цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйл ажиллагаанд мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм, хүдрийн олборлолт боловсруулалтаас үүсэх цацрагийн хаягдлын менежментийн дүрэм гэсэн ийм 2 үндсэн дүрмийн дагуу аж ахуйн нэгжүүд төслийн талбай дээрээ энэ үүссэн бага хэмжээний цацраг идэвхтэй хаягдлыг лендфил хэлбэрээр тэнд нь төслийн үйл ажиллагаа дуусахад бүгдийг нь тэнд нь менежмент хийж булшлах үйл ажиллагааг дүрмийн дагуу явуулах ёстой. Олон улсад ч гэсэн ийм дүрмүүд байдаг.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Дахиад л миний асуултад хариулсангүй. Маш их тодорхой асууж байгаа шүү дээ. Хүхрийн хүчлийн үйлдвэр барих уу. Манай 5 үндэсний үйлдвэрлэгч байгаа. Би Оюутолгойг оруулаад хэлж байгаа шүү дээ. Уг нь бол манай компани юм байгаа юм, чааваас уг нь. Эд нартайгаа ярилцсан уу? Хүхрийн хүчил 50 сая долларыг буюу зардлын 20 хувийг та нар гадагшаа гаргах гээд байна.

Монголчуудыг хордуулаад олж байгаа мөнгөний 20 хувь. Жилд 50 сая доллар. Хүхрийн хүчлийн үйлдвэр барих уу. Ажлын хэсэг байгуулах уу?

2 дугаар асуулт. Та нар аюултай хог хаягдал. Би тэр аюулгүй цацраг идэвхт хог хаягдлыг нь яриагүй шүү дээ. Аюултай, ноцтой хог хаягдал гээд 750 тонн жилд гарч байгаа. Үүний талаар боловсруулах үйлдвэр барих уу. Эсвэл гадагшаа өгөх гээд байгаа юм уу, Франц руу нь өгөх гээд байгаа юм уу? Энэ дээр ерөөсөө хариулсангүй. Нэг олон улсын стандарт яриад л таг. Энэ үйлдвэр барих уу, эсвэл барихгүй гэвэл хариул.

3 дугаарт, үгүй та нар Токаев чинь нэг их тийм үүгээр хэдэн төгрөг олж байгааг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ Монгол бол зэсийн орон гэж явдаг. Зэс олборлолтоороо дэлхийд эхний 10-д ороод явдаг. Тэгээд бид нар зэсийн баяжмал байдлаар экспортод гаргадаг. Яг катодын зэс үйлдвэрлэдэггүй. Нөгөө Эрдмийн Ачит ихт гээд энэ жижиг үйлдвэрүүд дээрээ багахан хэмжээний катодын зэс үйлдвэрлэдэг. Тэгэхээр бид нар зэсийн үйлдвэр барих ийм төлөвлөгөөтэй, зэс хайлуулах үйлдвэр барих төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Эхний ээлжийнхийг нь Эрдэнэт үйлдвэрээ түшиглэж тэр байршил дээр барина. Дараагийнхыг нь говийн бүсэд гээд.

Тэгэхээр Зэс хайлуулах үйлдвэрийг дагалдаж гарч ирэх энэ процесст гарч ирэх нэг зүйл бол хүхрийн исэл байгаа. Тэгээд энэ хүхрийн исэл эсвэл хуурай байдалд шилжүүлэх элементийн хүдэр, эс үгүй бол хүхрийн хүчил болгох гэдэг энэ зүйл байгаа. Тэгэхээр бид нар хүхрийн хүчлийг импортоор авахгүй, дотооддоо хүхрийн хүчлийн үйлдвэртэй болно гэдгийг энд тодотгож хэлье.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: Өглөөний мэнд хүргэе. Цөмийн энергийн хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Мөн Цөмийн энергийн хуультай хамтатгаад ер нь бид нар цаашдаа төрийн болон хувийн хэвшлийн бүх томоохон төслүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэх ёстой гэж үзэж байгаа. Өнгөрсөн 34 жилийн хугацаанд бид нар тухайн төслүүдийг хэний санаачилсан төсөл вэ, аль улс төрчийнх нь төсөл вэ, эсвэл аль намаас өргөн барьсан бэ гэдэг шалтгаанаар бие биедээ дандаа улс төрийн гацаа, тээг хийж, тухайн төслүүдийг хэрэгжүүлэхгүй хойшлуулдаг, дандаа улс төрийн тоглолт хийдэг, популизм хийдэг ийм 34 жил ард өнгөрөх ёстой.

2002 онд бид нар 5 дугаар цахилгаан станц гэдэг станцын тухай 2002 онд л ярьсан. Үүнээс хойш хэдэн ч удаа шав тавив, хэдэн ч удаа газар сонгов, хэдэн ч удаа тууз хайчлав, хэдэн ч удаа нээлт хийв. Ер нь 2009 онд Оюутолгойн төсөл гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэнээс хойш Монголд томоохон төслүүд бүр хэрэгжээгүй гэж үзэхэд бүгдээрээ бэлэн болно. Яг үүнтэй адилхан аж үйлдвэрийн парк, арьс ширний үйлдвэр, мөн бусад үйлдвэрүүд яг энэ замаар орсон. Бүгдээрээ улс төрчдөө даваагүй, өлгийндөө өтөлцгөөсөн. Энэ мэт Монгол Улсын эсрэг, төрийн эсрэг ийм ашиг сонирхлын зөрчлүүд явсаар байгаад өнөөдөр бид нар хөгжил яг энэ түвшиндээ ирчихсэн байгаа юм.

Тийм учраас томоохон бүх төслүүд бүгдээрээ хөдлөх ёстой. Ганцхан жишээ хэлэхэд Оюутолгой төсөвт сайнтай, муутай, хэл амтай 2009 онд эхэлсэн ч гэсэн өнөөдөр 5 тэрбум байсан ДНБ өнөөдөр 13 тэрбум болж, 2012 онд 13 тэрбум болж нэмэгдсэн. Үүнтэй адилхан бид нар бүх төслүүдийг явуулах хэрэгтэй. Гэхдээ Оюутолгой төсөл шиг 35 жилийн дараа Монголчууд ноогдол ашгаа авдаг, АМНАТ-аас өөр татвар, АМНАТ, нийгмийн даатгал, шимтгэлүүдээс бусад өөр ашиг орлого олдоггүй ийм төслүүдийг байж болохгүй.

Тэгэхээр Цөмийн энергийн тухай хуультай холбоотой, Ураны төсөл, Оюутолгой төсөл 2 ийм газар, тэнгэр шиг ийм 2 өөр нөхцөл байдал дээр бид нар гэрээ байгуулах гэж байна. Бас нэг жишээ хэлэхэд хамтарсан засгийн үед Оюутолгойн төсөл хөдөлсөн гэдгийг бүгдээрээ санах хэрэгтэй. Тэгэхээр одоо нэгэнт Засгийн газар хамтарчихсан байгаа тэр томоохон бүх төсөл хөтөлбөрүүдээ бүгдээрээ хэрэгжүүлье. Хувь хэвшил ерөөсөө хамаагүй. Бас бид олон нийтэд таалагдахын тулд хот популизм хийх ийм зүйлүүдээс улс төрчид татгалзмаар байна.

Тийм учраас бүгдээрээ хувийн болон хувьсгалын бүх төслүүдийг явуулъя. Гашуун сухайт төмөр зам явъя. Халзан бүргэдэй төсөл явъя. Бусад бүх төслүүдийг бүгдийг нь урагшлуулахад анхаардаг байя гэж байна.

Цөмийн энергийн тухай хууль бол үндсэндээ Монгол Улс дэлхийн зах зээл дээр ураны баяжмал дээр тоглогч болох, бид нар дараагийн орлогын эх үүсвэртэй болох, мөн бусад улсуудтай улс төрийн харилцаа үүсэх ийм боломжийг бид нарт энэ боломж бий болгоно. Тийм учраас бид энэ юунд 2007 онд Цөмийн энергийн хууль бид нар шинэ зүйл биш. 2007 онд бид нар энэ цөмийн энерги буюу ураны баяжмалыг экспортлох, олборлох үйл ажиллагаанд анхаарал тавьж байсан. Одоо бид нар 15 жилийн дараа дахиад хөдлөх гэж байна.

Тэгээд энэ мэт бид ингээд улс төржилтөөсөө болоод томоохон гэх бүх төслүүд 15-20 жилээр гацдаг ийм үйл явдлуудыг бүгдээрээ энэ парламент, энэ Засгийн газрын үед эцэслэж, үүнээс хойш том төслүүдээ улс төрийн шийдвэрээ гаргаж явуулдаг ийм шийдвэр маш чухал байна. Тийм учраас энэ Цөмийн энергийн хуультай холбогдуулан сая Ганбаатар гишүүн миний асуусан асуулттай давхцуулчихлаа.

Тэгээд би дахиад асууя. Ураны баяжмал хамгийн гол зүйл нь хог хаягдал юм байна лээ. Тэгэхээр энэ хог хаягдлын менежментийг маш чухлаар гэж үздэг юм байна. Тэгэхээр хог хаягдлын менежментээр яг ямар тодорхой зорилгууд тавьчихсан, зорилтууд тавьчихсан юм бэ? Энэ дээр ерөөсөө тодорхой хариулт өгөхгүй байна. Яг ийм хэмжээний үйлдвэр ингэж баригдана. Тэдэн тонн хог баяжмалыг ингэж борлуулна гээд. Хүмүүсийн гол эргэлзээ төрөөд байгаа юм чинь ерөөсөө л энэ шүү дээ. Аймшигтай хог хаягдал хаях гээд байна л гээд. Үүнийг хэлээч. Ер нь Улаанбаатарын утаанаас уран хамаагүй бага хортой шүү. Бид нар Улаанбаатарын утааг өнөөдөр уранаас хамаагүй бага юм шиг яриад, үгүй. Улаанбаатарын утаа бол аймшигтай хор. Тэгээд энэ яг Цөмийн энергийн комиссынхон, Мон-Атомынхон хог хаягдлын менежер нь нэг тодорхой тайлбарлаач. Яг тодорхой тайлбарлахгүй байна шүү дээ, та хэд.

Д.Амарбаясгалан: Цөмийн энергийн комиссын ажлын албаны нарийн бичгийн дарга Манлайжав хариулна. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон шинжээч Тэгшбаяр хариулт өгье.

Н.Тэгшбаяр: Яг тэр хог хаягдлын асуудлыг бол юу сая Манлайжав даргын хэлдгээр Олон улсын атомын энергийг агентлагаас гаргадаг дүрэм журмаараа Монголын цацрагийн аюулгүй норм, цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, хайхтай холбоотой энэ бүх дүрэм журмыг ашиглах ёстой. Тийм аюултай хог хаягдал гарахгүй шүү дээ. Зөвхөн байгалийн л ураны ийм л зүйл гарна. Тэнд ямар байгалийн уран газар дээр байсан нь, дээшээ ийм л юм гарна.

Тэгэхээр зэрэг энэ нэг тийм аюултай гээд нэг цөмийн зэвсэг шиг хэлээд байх хэрэггүй юм байгаа юм л гэдгийг л хэлэхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон нэмж хариулъя.

Б.Мөнхтогтох: Ураны төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал дээр аюултай хог хаягдлын асуудал яригдаж байгаа. Тэгэхээр одоо яг Монгол Улсын хэмжээнд байгаа зохицуулалтаараа аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй 25 аж ахуйн нэгж байна. 2023 оны байдлаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд ирсэн мэдээллээр тухайн үйлдвэрүүд 12200 тонн хог хаягдлыг боловсруулсан байна. Урт хугацаандаа ямар бодлого барьж байна гэхээр Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 41-д Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл гэж, 2022 оны 377 дугаар тогтоолд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар 20 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах гэж тус тус тусгагдсан байгаа. Эдгээр ажлын хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт 20 га газрыг олгосон байгаа. Цаашдаа урт хугацаандаа аюултай хог хаягдлын үйлдвэр барих үйл ажиллагаа үргэлжлээд явагдана.

Д.Амарбаясгалан: Мон-Атом компанийн захирал Далайжаргал нэмж хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Д.Далайжаргал: Шижир гишүүний асуултад хариулъя. Энэ төсөл ирэхэд 3 янзын хог хаягдал гарах юм. 3 янзын хог хаягдлыг 3 аргаар л янзална.

1 дүгээрт, аюултай хог хаягдал гээд байгаа нь шатах тосох материал, дугуй энэ тэр гээд тиймэрхүү материалууд байгаа байх. Түүнийг аюултай хог хаягдлын тусгай үйлдвэр байгуулна.

Тэр бага цацрагт хог хаягдал гэдэг нөгөө шар нутгийн сав, бээлий эд нар гэсэн тийм юмнууд байгаа, түүнийг булшилна.

Ердийн хог хаягдлыг шатаана гэсэн ийм 3 аргаар хийхээр Француудтай яагаад тохирчихсон байгаа.

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Сайн байцаана уу? Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ уул уурхайн эдийн засагтай газар, гадаадын хөрөнгө оруулалт, энэ Цөмийн энергийн тухай хуулийг ч гэсэн ер нь бүгд дэмжиж байгаа. Дэмжихээс ч өөр аргагүй. Одоогийн бидний нөхцөл байдалд. Тэгэхдээ хэд хэдэн асуудлууд байна. 2 гол, 1 дагалдах маягийн.

1 дэх асуулт нь энэ хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэр дотроо цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, хүний эрүүл мэнд, нийгэм, байгаль орчныг хамгаалах нөхцөл бүрдэнэ гээд дурсчихсан байна. Тэгээд харахаар яах аргагүй өмнөх байгаа хуульдаа ч тэр, энэ шинээр орж ирж байгаа хуульдаа ч гэсэн энэ байгаль орчны үнэлгээ хийгдэж байгаа, хийгдэнэ гэсэн үг өгүүлбэр хэсгүүд байна. Гэтэл яг хэн хүний эрүүл мэнд, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тухай огт дурсаагүй байгаа юм. Энэ яагаад огт дурсагдаагүй өнгөрчихсөн бэ гэдэг дээр тайлбар авмаар байна, 1 дүгээрт.

2 дугаарт, тэгээд бид нар ер нь бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ, тийм ээ. Одоо энэ татвар, төлбөр тооцоо, мөнгө, эдийн засаг энэ маш чухал. Тэгэхдээ эрүүл мэнд чинь үүнээс хамгийн чухал уу, үнэ мөнгө төгрөгөөр тооцохоор ямар байх вэ гэх мэтчилэн зөндөө асуудлууд байгаа. Үүнтэй холбоотойгоор бид нар энэ ажлын хэсэг дээр жишээлбэл орж байгаа хүмүүс нь хяналтын байгууллагад Цөмийн энергийн агентлаг, Байгаль орчны яам, тэгээд бүгдээрээ орчихсон байгаа боловч Эрүүл мэндийн яам юм уу, мэргэжлийн холбогдох хүмүүс ерөөсөө энэ ажлын хэсэгт орж оролцоогүй байна. Оролцуулаагүй байна. Үүний тайлбарыг авчихмаар байна.

3 дахь буюу дагалдах асуудал нь яах вэ, энэ өмнө хууль дээрээ 4 дэх заалт дээр энэ хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэлх жилээр гэж зааж өгч байсан юм байна. Түүний 10 хүртэлх жилийнх нь үндэслэл нь юу байсан юм. Одоо 20 болгож байгаа шалтаг шалтгаан нь юу вэ гэдэг дээр тайлбар авъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Яг энэ тийм, Ганмаа гишүүн маань эмч, анагаахын салбарын хүн учраас хүн ардынхаа эрүүл мэндийн талд санаа зовж явдаг, тэгээд энэ талдаа асууж байна. Тэгээд энэ дээр бид бүхэн би дөнгөж сая хэлэнгүүт чинь л бодлоо. Энэ ажлын хэсэгт яг энэ шууд эрүүл мэндийн салбараас хүн оруулах байж гээд. Тэгэхээр энэ тал дээр бид бүхэн анхааръя. Яагаад гэхээр энэ дээр бид нар нөгөө Цөмийн энергийн комиссынхон, ажлын албаны дарга эндээс ороод явчихсан. Энэ дотор Цөмийн энергийн комисс дээрээ бид нар энэ эрүүл мэндийн салбартай холбоотой, энэ цөмийн энергитэй холбоотой, радио идэвхт бодистой холбоотой асуудлуудыг аваад явдаг. Энэ дотор эмнэлгийн мэргэжлийн хүмүүс байгаа. Тэгэхээр яг энэ удаагийн энэ хуулийн өөрчлөлтийн ажлын хэсэгт оруулаагүй юм байна гэдгийг хэлье.

Тэр юун дээр нь байгаль орчны үнэлгээ, яасан үнэлгээ хийх талаар саяын асуудал дээр гэдэг дээр Мон-Атом нэмээд хариулт өгчих.

Д.Амарбаясгалан: Далайжаргал захирал нэмж хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Д.Далайжаргал: Гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн хугацаанд 2019 оноос хойш нийтдээ 8 удаа хяналт шалгалт үнэлгээ хийсэн юм. Түүн дотор гадаадын 2 хийсэн нь Олон улсын атомын эрчим хүчний агентлаг 21 онд, Байгаль орчны үнэлгээ хийдэг Канадын дэлхийд 2-т ордог компани байгаль орчны үнэлгээ хийсэн. ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар 3 удаа хийсэн. Тэнд Эрүүл мэндийн яам, хүн амын эрүүл мэнд, байгаль орчин гээд л бүгдийг нь тусгасан байдаг. Тэгээд энэ бүх тэр үнэлгээнүүдээ Засгийн газрын хуралдаанд орж танилцуулсан байдаг юм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Манлайжав дарга хариулт өгье.

Г.Манлайжав: Ганмаа гишүүний асуултад нэмэлтээр хариулт өгье өө. Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнд Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ажилладаг. Тэр дундаа Улаанбадрах сум дээр Дорноговь аймгийн энэ хэсэг дээр хүн амын эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаар бид нар Эрүүл мэндийн яамтай сүүлийн 3 жил ажиллаж байна. Энэ судалгаануудыг Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн энэ чиглэлийн судалгаа хяналтуудыг хийж байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя. Ганмаа гишүүн тодруулж асууна. Ганмаа гишүүн тодруулж асууя.

Д.Ганмаа: Байгаль орчны үнэлгээг харьцангуй сайн хийгээд болоод байдгийг би мэдэж байгаа. Яг хүний буюу эрүүл мэндийн нөлөөллийн энэ үнэлгээ яаж хийгддэг вэ? Би яагаад асуугаад байна гэхээр сүүлийн бараг 20-оод жил Монголын улсын болон хувийн бүх лабораториуд дээр би ажиллаж үзэж байсан. Энэ эрүүл мэндийн үнэлгээ бол мэдээж лабораториор зөвхөн зохицуулагдахгүй. Тэгэхдээ зөвхөн лабораторийн хэсгийн даге ярихад л хүний нөөцийн асуудал, ажиллуулж байгаа хүчин чадал, төхөөрөмж, ганц 2 яг боломжийн төхөөрөмж нь байдаг ч гэсэн тэрийгээ хэзээ ч ажиллуулдаггүй. Яагаад гэхээр ментенс байхгүй, хүний нөөц нь байхгүй, оруулж ирж байгаа тэр нөгөө хэрэгсэл, уусмал, шингэнийх нь хүчин чадал, боломж нь байхгүй. Тэгэхээр чинь зэрэг би яг энэ сайдын хажуу дахь нэг зөвлөлөөр зөвшөөрлийг зүгээр уурхай нээхэд жишээлбэл хүний эрүүл мэндийн зөвлөлөөр нэг оруулдаг. Тэгэхдээ тэр зөвлөл яаж ажилладгийг би мэднэ. Зарчмын хувьд ч дотор нь байсан одоо юу билээ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Тийм. Энэ эрүүл мэндийн асуудал дээр бодитой дүгнэлттэй болохгүй бол болохгүй. Маш тодорхой хариулттай болох хэрэгтэй. Дан ганц байгаль орчин талаасаа илүүтэйгээр тийм ээ.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би асуулт гэхээсээ илүүтэй саналаа хэлье. 20 гаруй жил гацсан энэ хөтөлбөрийг, төслийг хориодохон хоногийн дотор ингээд Их Хурал Цөмийн энергийн тухай хуулийг баталж өгөх гэж байна.

Тэгэхээр парламентад суудалтай 4, 5 улс төрийн намуудын байр суурь үндсэндээ зарчмын хувьд дэмжиж байгаа харагдаад байгаа юм. Тэгээд Засгийн газар хамтарсан учраас энэ төслийг зарчмын хувьд дэмжээд байх шиг байгаа юм. Улс төрийн намууд. Тэгэхээр 20 гаруй жил юуны төлөө ингэж гацсан юм бэ гээд харахаар үндсэндээ л улс төрч нар, улс төрийн намууд л аливаа энэ төсөл, хөтөлбөрийг гацаадаг юм байна гэдэг нь харагдаад байгаа байхгүй юу. Зарчмын хувьд саналаа нэгтгээд, байр сууриа нэгтгээд, дэмжээд явъя гэвэл аль ч төсөл, хөтөлбөрүүдийг, аль ч хууль тогтоомжуудыг дэмжээд явах ийм байдал харагддаг юм байна гэдэг нь энэ Цөмийн энергийн тухай хуулиас харагдаж байгаа юм.

Тэгэхээр энэ Засгийн газар энэ парламентад их баярлах ёстой юм байгаа юм. Энэ олон жил гацсан, олон жил улс төржсөн, ийм төсөл, хөтөлбөрүүдийг Улсын Их Хурал 20 хэдхэн хоногийн дотор ногоон гэрлээр нь баталж өгч байна шүү дээ. Үндсэндээ. Би нэг юмыг гайхаад байгаа юм, бас. Энэ хэлэлцүүлгийн шатад яагаад

энэ төсөл, хөтөлбөртэй холбоотой нөгөө олон олон жил улс төржүүлээд, олон жил юм яриад байсан, иргэний нийгмийн байгууллагууд гэдэг юм уу, орон нутгийн ард иргэд эсэргүүцэл гарахгүй байгаа юм бол гэж би гайхаад байсан юм. Одоо тэр Ховд аймагт тэр Халзан бүргэдэйн орд гээд өнөөдөр ямар юм болж байна. Түүн шиг ард иргэд нь тийм юм гаргахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ цаг нь ирэхээр, учраа нь тохироо нь бүрдэхээр ард иргэд энэ олон жилийн хугацаанд энэ төсөл, хөтөлбөрийн ач холбогдлыг, байгаль, нийгэм, эдийн засагт үзүүлэх учир холбогдол, ач холбогдлыг нь ойлгоод ирэхээр үнэнд гүйцэгдэж үнэхээр цаг нь болжээ гэж ингэж бас нийгмийн хүлээлт бий болдог юм байна гэдэг нь энэ төсөл, энэ хуулийн өргөн барьж, явцаас харагдаж байна.

Тийм учраас өнөөдөр ингээд энэ Цөмийн энергийн тухай хууль эцэслэн батлагдах гэж байна. Энэ хуулийг бариад бид нар Татварын хууль, Хөрөнгө оруулалтын хууль, хэд хэдэн компанийн хууль гэсэн хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж байна. Одоо энэ хуулиудаа бариад хөрөнгө оруулагч талтай та бүхэн хөрөнгө оруулалтынхаа гэрээг хийх байх. Үндсэндээ нөгөө саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэг шиг гэрээгээ байгуулахын тулд урьдчилж, хууль дээр байгаа алдаа мэдгээ засаж, ингэж оруулж ирж байгаа хэлэлцэж байгаа гэж би хувьдаа ойлгож байгаа. Одоо энэ хуулиуд батлагдсанаар та бүхэн Оюутолгойн гэрээг давтахгүйгээр, ямар нэг тодорхой хугацааны дараа элдэв янзын гоншигнохгүйгээр, Монголын ард түмэнд ашигтай байхаар, орон нутгийн ард иргэдэд ашигтай байхаар ийм гэрээ хөтөлбөрийг хийх ёстой шүү. Энэ бол Засгийн газрын хөрөнгө оруулагч талтай хийх гэрээ, үүрэг.

Тийм учраас та бүхэнд хамаг том үүрэг, ачааны хүнд оногдож байгаа. Энэ гэрээг ашигтай хийх, Монголын талд дийлэнх олонх нь ашигтай байх, өргүй байх, байгаль орчноо эвдэн сүйтгүүлэхгүй байх. Эргээд тодорхой хугацааны дараа бид нар элдэв янзын гоншигносон тайлбар хэлэхгүйгээр ингэж Их Хурал Засгийн газрын өргөн барьсан бүхий л хуулийг чинь ингэж ногоон гэрлээр нь, өргөн баригдсанаар нь баталж өгч байгаа шүү. Энэ бол 126 гишүүнтэй парламент болсны нэг давуу тал харагдаж байгаа гэж ойлгож байгаа.

Тийм учраас одоо та бүхэнд ашигтай гэрээ байгуулах л цаг хугацаа үлдэж байна. Энэ хөтөлбөр төслийг явуулах эр зориг, улс төрийн шийдвэр үлдэж байна. Тийм учраас та бүхэн Монгол Улсдаа, ард иргэддээ ээлтэй, нэг ч гэсэн томоохон хөтөлбөр төслийг зөвхөн уул уурхай биш томоохон үүд хаалгыг нээж байна. Монголын эдийн засагт.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ.

Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Түрүүн тэр нэг эрүүл мэндийн байгууллагатай холбоотой юун дээр Монголд нөгөө Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв гээд байж байгаа шүү дээ. Хүн, нийгэм, энэ хот байгаль хоорондоо яадаг вэ гээд тэр эд нараас оруулчихгүй юу даа.

Тэгээд энэ Цөмийн энергийн тухай хууль, Цөмийн энергийн хуулийг дагаж дагалдаж орж байгаа хуулиудын өөрчлөлт энэ бүхнийг хэлэлцэж байгаа нь 1 дүгээрт, өнөөдөр байгаа Монгол Улсын яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар ямар нэг гэрээ байгуулбал Монгол Улсад алдагдалтай болно гэдэг ийм дүгнэлтийг гаргасны үндсэн дээр энэ хуулийн өөрчлөлтийг оруулж ирж байгаа гэж

ойлгож байгаа. Үүнийгээ энэ чуулганы нэгдсэн хуралдаан дээр үгүй ээ, одоо байгаа хуулиар хийсэн ч алдагдалгүй байна. Нэг бол энэ хууль өөрчлөхгүй бол Монгол Улсад алдагдалтай, Монгол Улсад хортой гэрээ хийгдэх гээд байгаа, нэг бол гэрээ хийх боломжгүй байгаа юм гэдгээ ялгаж салгаад хэлчихмээр байгаа юм.

2 дугаарт нь, бид нар өнөөдөр ингээд парламент өөрөө хууль хэлэлцэж байгаа хэр нь ашигт малтмал яах вэ, уран гээд, үүнийг олборлох гэж байгаа Монголтой гэрээ байгуулах гэж байгаа гэдэг компанийн гэрээний тэр олборлолтын тухай асуудал яриад байх юм. Үгүй ээ, бид нар чинь хуулиа хэлэлцэж байна шүү дээ. Юун Рона эд нар өөр ямар компани, хэзээ орж ирээд, ямар гэрээ байгуулаад, юу олборлох гээд байгаа гэдэг тухай ярих ёсгүй шүү дээ.

Тэгэхээр нөгөө ашиг сонирхлын буюу Рона компанийн төлөөх Монгол Улсын Их Хурал хууль батлах гээд байгаа юм уу, үгүй юм уу. Үүнийгээ ялгаа заагтай болгохгүй бол Их Хурлын гишүүн болгон чинь Рона компани ярьдаг болчихлоо. Уг нь өнөөдөр энэ үйлчилж байгаа хуулийг өөрчлөхгүй бол Монгол Улсад хохиролтой гэрээ юм уу, Монгол Улсад ийм хөрөнгө оруулалт юм уу, ямар нэг зүйл эрхлэх боломжгүй гэдэг хуулиа л яримаар байгаа байхгүй юу. Хууль тогтоогч байгууллагын хувьд. Хууль тогтоож байгаа эрхэм гишүүд минь бас энэ тухай бодмоор байгаа юм.

Дээрээс нь нэмээд Цөмийн энергийн хууль дагалдах хуулиудад өөрчлөлт орж байгаатай холбоотой Монгол Улсад энергийн төрлийн бүх эрчим хүч, уул уурхай, ашигт малтмал энэ чиглэл рүү бүх зүйлийнхээ үүд хаалгыг нээж байна гэж ойлгож байгаа. Хамгийн эрсдэлтэй буюу хамгийн зөв, буруу гэж маргадаг, энэ хэсэг дээрээ хуулийнхаа өөрчлөлтүүдийг явуулаад үүд хаалгыг нээж байгаа бол бусад эрчим хүчний эх үүсвэрүүд, бусад тэр газрын ховор элемент тийм ээ, янз бүрээр дүгнэгдээд байгаа энэ зүйлүүдийнхээ үүд хаалгыг нээж байгаа юм уу, үгүй юм уу гэдэг. Энэ тухай хуулийнхаа энэ алхмууд маань ингээд цаашаа явж байгаа юм. Монгол Улс уул уурхайн баялгийн хувьд, эдийн засгийн хувьд нээлттэй байх энэ чиглэл рүү ажиллаж байна гэдгээ ойлгомжтой хэлмээр байгаа юм.

Эцэст нь манай ажлын хэсэг, манай энэ Их Хурлын гишүүд, энэ Засгийн газраас оруулж ирж байгаа төслүүд, энэ зүйлүүд бол хуулийн өөрчлөлт явж байгаа гэдгээ тодотгож, энэ дээрээ цэг тавиад, тэр дараа нь байгуулагдах хууль өөрчлөгдсөний дараа байгуулагдах ямар нэг гэрээн дээр бол Монгол Улсын ард иргэд, нийт иргэдийн төлөө хатуу байр суурьтай байна гэдгээ илэрхийлж энэ хуулийн төслийг, өөрчлөлтийг дэмжиж байгаа шүү. Энэ дээр та бүхэн байр сууриа адилхан байгаа бол адилхан гээд, үгүй байгаа бол үгүйгээ илэрхийлчихсэн нь зүйтэй байх гэж асууж байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Батын Батбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ хууль өмнөх хуулиар бол 34 хувийг улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бол 51 хүртэл, хувийн хөрөнгөөр хайгуул хийсэн бол 34 хүртэл гээд ингээд заачихсан, өөр сонголтгүй байгаа. Тэгэхээр Цөмийн энергийн хуульдаа бид бүхэн энэ гаднын, ганцхан энэ Рона компанитай хийх хөрөнгө оруулалтын гэрээ ч биш, ер нь энэ 34 хувийг тусгай АМНАТ-аар сольж болох юм гэдэг энэ зүйлийг В вариант гэдэг шиг нэг нөхцөл болгож, ингэж оруулж өгч байгаа гэдгийг хэлье. Үүнийг оруулснаараа бид бүхэн, өмнө нь бид бүхэн нэг 34 хувийн гэрээг гаднын хөрөнгө оруулалттай компанитай хийгээд, тодорхой хэмжээний шүүмжлэл дагуулдаг. Тэгэхээр бид бүхэн 19 оны Үндсэн хуулиа өөрчлөлтөө дагаад Монголын ард түмэнд, Монгол Улсад

дийлэнхийн ашигтай байх гэдэг энэ бодлогыг хэрэгжүүлэх үүднээс энэ хуулийг оруулж ирж байгаа.

Тэгэхээр энэ хуулийн дараагаар Монголд дийлэнх олгох нь ашигтай байх нөхцөл нээгдэнэ гэж ингэж таны асуултад хариулъя.

Тэр яг үнэн. Энэ компанийн уг нь, энэ хөрөнгө оруулалтын гэрээний асуудал энэ тэрийг бол бид бүхэн хуулийн түвшинд нь, хууль тогтоогчийн түвшинд л Их Хурал хараад явчихмаар байгаа юм. Тэгэхдээ заримдаа яг үнэндээ гэрээний деталь руу нэлээн, компанийн хувь, хувьцаатай холбоотой асуудал руу хүртэл ингээд детальный орж байгаа юм. Тэгэхээр Монгол Улсад Их Хурлыг Их хурал байгаа, Их Хурлыг нь томилж өгсөн Засгийн газар үйл ажиллагаа явуулж байгаа, мөн тэнд энэ тухайлан энэ Рона компанитай энэ ураны төсөл дээр төрийн өмчийн 34 хувийг төлөөлж, төрийн өмчит Мон-Атом компани энэ дээр орж байгаа. Тэгээд энэ хүрээндээ энэ гэрээг яригдаж байгаа. Ажлын хэсэг бол байгуулагдаад энэ төлөөлөөд ажиллаж байгаа. Тэгээд энэ дээр манай Пүрэвдорж гишүүн маш амжилттай ажиллаж байгааг энд хэлье.

Энэ гэрээ байгуулагдсанаар Монгол Улс энэ салбартаа, ялангуяа энэ уул уурхайн салбартаа, энергийн салбартаа энэ гаднын хөрөнгө оруулалт дээр тодорхой нээж өгч байна, хамтран ажиллах олон төрлийн ялангуяа энэ улс төрийн гацаануудаасаа гаргаж байна гэдэг энэ мессеж олон улсад маш чухал байгаа юм. Одоо үүнийг харж байгаа маш олон гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтууд байгаа. Гацчихсан төслүүд ч хараад зогсож байгаа. 2 хөрштэйгөө хийчихсэн гацчихсан янз бүрийн асуудлууд бүгдээрээ үүнийг хараад зогсож байгаа.

Тэгэхээр таны ойлгож байгаа энэ хууль батлагдсанаар энэ гаднын хөрөнгө оруулалт, ялангуяа энэ уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын энэ лайн ногоон гэрлээ асааж байгаа гэдэг мессежийг олон улсад өгөх талаасаа өндөр ач холбогдолтой гэдгийг энд хэлье. Тэгээд Монгол бол уул уурхайн салбараас маш их хамааралтай улс орон болсон. Тэгэхээр бид бүхэн энэ хугацааг маш сайн ашиглах ийм шаардлага Засгийн газарт байгаа ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Боллоо. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна. Алга байна.

Дамбын Батлут гишүүн асуулт асууна. Алга байна.

Агваанлуvsангийн Ундраа гишүүн асуулт асууна.

А.Ундраа: Та бүхний амгаланг айлтгая. Энэ Цөмийн цэргийн тухай хуульд өөрчлөлт орж байгаа асуудал бол зарчмын хувьд дэмжиж байгаа, зөв зүйтэй, бас түрүүнд асуулт асуухад Мон-Атом компани өмнөх өр төлбөрийг барагдуулсан гэж байсан, тэр сайшаалтай байна.

Миний асуулт бол бид нарын өнөөдөр хэлэлцээд байгаа энэ өөрчлөлтийн мөн чанар нь нь харахад тэр дандаа уул уурхайн салбартай холбоотой, олборлолттой холбоотой асуудлуудыг гаргаж ирж асууж байна. Тэр нь ч өнөөдөр орж байгаа өөрчлөлтийн гол агуулга юм.

Тэгээд эргээд бодоход ер нь энэ Ашигт малтмалын тухай хуулиар биш Цөмийн энергийн тухай хуулиар яагаад зохицуулах ёстой болсон юм бэ гэдэг асуулт

гарч ирж байгаа байхгүй юу. Энэ бол маш их зорилготойгоор, тэгээд тодорхой үндэсний амбицтайгаар хийсэн ажил гэж би харж явдаг. Тэгэхээр энэ хуулийнхаа нэрнээсээ авхуулаад цөмийн энерги гэж туссан байгаа. Тэгэхээр өнөөдөр Засгийн газраас төлөөлөөд ярьж байгаа Туваан сайд байх шиг байна. Тэгэхээр би энэ улс төрчдийн амбиц дарж явах ёстой, улс төрчдийн амбицыг дармаар. Харин улс орны амбиц, улс үндэстний амбиц гэж байх ёстой. Тэр амбицын хүрээнд гэх үү, тэр хөгжлийн бодлого, зорилгын хүрээнд бид нар цөмийн энергийн асуудлыг гаргаж тавьж явсаар ирсэн. Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусчихсан байгаа. Монгол Улсын бусад хөгжлийн баримт бичгүүдэд ч цөмийн энергийн асуудал туссан байгаа л даа.

Тэгэхээр танай яамны эрхлэх асуудлын хүрээнд биш ч гэсэн ажлын хэсгийн дарга Пүрэвдорж гишүүн хариулах юм уу? Цөмийн энергийн асуудлаар, тэгээд дараа дараагийн үйл ажиллагаатай холбоотойгоор Цөмийн энергийн комиссоос нь энд надад нэг хариулт өгмөөр байна. Энэ хууль батлагдсанаараа яах вэ, ашигт малтмалын хэсэг нь ингээд явчихдаг юм байж. Одоо уран олборлолоо гэхэд тэр чинь шар нунтаг байдлаар гаргаж авна тийм ээ. Тэгээд энэ хамгийн анхны бага бага баяжмалтай гэхээс бага концентрацтай тийм ээ. Тэгээд цаашлуулаад мэдээж хөрвүүлэх, баяжуулах, түлш үйлдвэрлэх гээд энэ хэсгүүд рүү бид одоохондоо орох чадал тэнхээ байхгүй нь үнэн ч гэсэн бид чинь улс үндэстэн гэдгээрээ амбицтай, амбицлаад бид нар Атомын станц гээд хөтөлбөртөө тусгачхаад яваад байгаа биз дээ.

Тэгээд эрчим хүчний цэвэр эх үүсвэр хэрэгтэй гэдгээр нь бүгдээрээ санал нийлээд, үүнийг тэр Засгийн газрын мөрийн хөтөлбөртөө оруулж батлаад, тэгээд үйл ажиллагаа нь хэрэгжээд ингээд явж байгаа. Тэгэхээр энэ зорилт зорилтынхоо төлөө ер нь ямар байдлаар ажиллая гэж бодож байгаа юм бэ? Тэгэхээр ингээд эргэн тойрноо харах юм бол хүний нөөцийн асуудал ер нь хэр байна вэ гэдэг дээр өнөөдөр салбарын эрдэмтэд нь энэ ажлын хэсэгт нь ороод ажиллаж байгаа нь зөв зүйтэй. Тэгээд түүхэн үүднээсээ харсан ч Монгол Улс маань Дубна дахь цөмийн судалгааны төвийн гишүүн явж ирсэн. Швейцарын сууринд оролцоотой ажилладаг олон эрдэмтэн, судлаачид ийш тийшээ явж судалгаа, шинжилгээ хийж байгаа. Одоо математик, физик, хими, биологийн олон улсын олимпиадад орж медаль авч байгаа хүүхдүүдийг харвал үнэхээр бахархмаар байна шүү дээ.

Тэгэхээр бид хүн байхгүй биш байгаа. Үүнийг бодлогоор чиглүүлэх, төсвөөр дэмжих, байгалийн шинжлэх ухааныг бодлогоор дэмжих ажил ярьж байж, дараа дараагийн энэ нөгөө цөмийн энергийн асуудал, цөмийн цахилгаан станцын асуудал, эрчим хүчний цэвэр эх үүсвэрийн асуудал, шинжлэх ухаан технологийн бусад хөгжлийн асуудлыг ярих түлхүүр гарц нь нэмэгдэнэ биз дээ. Тэгэхээр өнөөдрийн байгаа байдлаа харахад манай төсөв яг шинжлэх ухаанч тал дээрээ шинжлэх ухаанч бус. Хамгийн тийм өрөвдөлтэй, зүгээр нэг жагсаалт байдлаар энэ мега төслүүд гэж байгаа нь ч гэсэн ямар нэгэн тооцоо, судалгаагүй мөрөөдлийн жагсаалт шиг оруулчихсан. Тэгээд түүн дээр ажиллах хүний нөөц, түүн дээр ажиллах мэдлэг оюунаа хаанаас гаргаж, яаж бэлдэх гэж байгаа талаар ямар ч системтэй юм алга.

Тэгэхээр би Туваан сайдаас асуумаар байна. Тэгээд Манлайжав даргаас асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Ундраа гишүүний асуултад хариулъя. Тэгээд манай энэ ялангуяа энэ цөмийн энергитэй холбоотой энэ салбарт манай Ундраа гишүүний оролцоо, яг энэ салбарын үндсэн мэргэжлийн хувьд чухал байр сууринуудыг илэрхийлж байгааг талархалтай байна. Бид нар анх энэ төсөөлж байхдаа энэ Ашигт малтмалын тухай хуулийг цуг оруулж ирье гээд энэ 2 хуульдаа зэрэгцүүлээд оруулж ирье гэдэг ийм концепцоор явж байгаад Засгийн газар дээр Ашигт малтмалын хууль маань өөрөө Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа. Дээрээс нь нэлээн өргөн хэлэлцүүлэг агуулга дагуулах гээд байгаа ийм байсан учраас, дээрээс нь тодорхой энэ цөмийн энергитэй холбоотой, ашиглахтай холбоотой, заалтууд нь харьцангуй сууж өгсөн учраас энэ удаадаа энэ Цөмийн энергийн хуулийг, хуульдаа энэ 34 хувийн хувьцааг тусгай АМНАТ болгож хөрвүүлэх энэ боломжтой хэсгийг нь гол болгож, үзэл баримтлалдаа оруулж ирсэн гэдгийг хэлье.

Мөн дагаад удахгүй Ашигт малтмалын тухай хууль орж ирнэ гэдгийг хэлье.

Мэдээж энэ төсөл амжилттай болоосой, дээрээс нь хүн амын эрүүл мэндэд болон улс оронд хэрэгтэй байгаасай гэдэг талаасаа адилхан байгаа. Бид бүхний амбиц бол Монгол Улсын амбиц нэг байгаа гэдгийг хэлье.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 14 мега төсөлд энэ Рона компанитай байгуулах энэ төсөл орж ирсэн нь өөрөө нэлээн ач холбогдол дагуулж, энэ олон жил гацсан төслийг цааш нь явуулах ийм анхны алхмыг нь хийж өгсөн. Энэ ч утгаараа энэ асуудал явж байгаа.

Дээрээс нь та бүхний баталж өгсөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бид нар нэлээн томоохон амбицтай зүйл тусгаж өгсөн нь АЦС-ын суурь судалгааны ажлыг эхлүүлнэ гээд. Энэ бол бас л яг энэтэй ингээд хавсраад явах ийм ажил гэдгийг хэлье. Энэ жил дээс эхлээд Цөмийн энергийн комисс Аж үйлдвэржилт, эрдэс баялгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээр ирж байгаа. Өмнө нь боловсролын салбар дээр байсан. Тэгэхээр Цөмийн энергийн комисс манай салбар дээр ирж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг тантай цаашид нэлээн олон ярих асуудлууд байгаа гэдгийг хэлье. Цааш нь хөгжүүлэхэд.

Хүний нөөцийн хувь дээр мэдээж бид бүхэн дээр тодорхой асуудлууд байгаа. Бид нар яг энэ салбартаа энэ чиглэлдээ зориулж, хүмүүсээ бэлтгэх, анх өмнө нь бэлтгэгдсэн боловсон хүчнүүд хөдөлмөрийн насны хувьд ч гэсэн нэлээн өндөрсөж байгаа ийм проблемууд байгаа гэдгийг хэлье. Тантай санал нэг байна.

Мөн тун удахгүй Цөмийн ажиллагааны тухай 94 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 80 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхох 3 конвенц бас УИХ руу орж ирэхээр Засгийн газраар хэлэлцэгдээд орж ирсэн. Бид бүхэн үүнийг энэ Цөмийн энергийн хуультайгаа хамтатгаад оруулъя гэж бодсон боловч өргөн барих процесс нь тусдаа яг хуультай адилхан явдаг учраас энэ конвенцуудаа оруулж ирж байгаа.

Тэгээд энэ дээр ч гэсэн та бүхэн маань хэлэлцэх үеэр, соёрхон батлах үеэр санаа оноонуудаа хэлээд явах ийм боломжтой. Тэгэхгүй бол энэ конвенцууд нэлээн удаан хугацаанд хэлэлцэгдэхгүйгээр цаг хугацааны тупикт орох ч гэсэн ийм санцад орох ч гэсэн ийм асуудлууд байгаа учраас бид бүхэн өнөө маргаашгүй Улсын Их Хурлын даргад конвенцоо өргөн бариад, ирэх 7 хоноогоос ингээд хэлэлцүүлгийнхээ шат руу ороод явна гэдгийг энэ ташрамд мэдээллийн чанартай хэлье.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүний хувиар Нямтайширын Номтойбаяр гишүүн нэмж хариулт өгье.

Н.Номтойбаяр: Гишүүдэд нэг нэмэлт мэдээлэл өгмөөр байна. Өнөөдөр Цөмийн энергийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд ингээд дуусчих асуудал ердөөсөө биш. Ажлын хэсгээс зөвлөмж, чиглэлүүд гарна. Энэ хуулийг батлахдаа, хуулийн зүйл, заалтуудыг хэлэлцэхдээ, ямар ойлголтоор энэ хуулийг баталж байгаа юм, тэгээд Их Хурлын гишүүдээс гарч байгаа санал, санаачилгууд, анхааруулж хэлж байгаа маш олон зүйлүүд байгаа. Энэ бүгдийг протоколыг нэгтгэж авч байгаад, зөвлөмж чиглэл гаргана. Оюутолгойн жишгээр л явна л гэсэн үг.

2-т нь юу вэ гэхээр нэг зүйлийг гишүүдэд анхааруулж хэлмээр байна. Энэ нэг компани нэг гаднын байгууллагатай байгуулж байгаа гэрээ хэлцэлд зориулсан хууль ердөөсөө биш, нийтлэг байдлаараа л үйлчилнэ. Тэгээд үүнийг хэдүүлээ анхааралтай цаашдаа ярихгүй бол энэ чинь гаднынхан ч гэсэн энэ чуулганыг үзэж байгаа шүү дээ. Синхронный орчуулгатай л үзэж байгаа байх. Монголчууд чинь эхлээд гэрээ хэлэлцээрийнхээ асуудлыг урьдчилж тохироод, түүндээ нийцүүлээд хууль батлаад, тэгээд дараа нь гэрээ нь орж ирээд явчихдаг юм байна гээд. Тэгээд энэ бол маш буруу жишиг тогтоно. Дараа дараа нь бид нар маш том шахалт дарамтад орж эхэлнэ.

Тэгэхээр энэ нэг хандлагаа бид нар их зөв тайлбарлаж ярихгүй бол буруу ойлголтыг өгөөд, адаглаад л хөрш орнууд өө та нар чинь ингэдэг биз дээ гэдэг иймэрхүү зарчим бариад эхэлбэл их өрөөсгөл зүйл болно шүү. Тэгэхээр хэдүүлээ нэг үгэндээ анхаармаар байна. Ажлын хэсэг ч гэсэн хариулахдаа энэ дээр алдаад, мэр сэр алдаад байна. Тэгэхээр зөвхөн энэ нэг компанид зориулсан хууль ердөөсөө биш. Түрүүн Сандаг-Очир гишүүн хэлчхэв үү, хэн хэлчхэв. Энэ чинь арваад лиценз байгаа гээд бүгдэд нь л хамааралтай шүү дээ. Цаашдаа ч ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа цуглая.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрөөтэй 1 санал байгаа. Зарчмын зөрөөтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно гэж дэгийн хуульд заасан байгаа. Ингээд үг хэлэхээр 4 гишүүний нэр ирсэн байна. Жамбалын Ганбаатар, Дуламын Бум-Очир, Амгаланбаатарын Ганбаатар, Сайнхүүгийн Ганбаатар гэсэн 4 гишүүний нэр ирсэн байна.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн ирцийн дарааллаар Ганбаатар гишүүн үгээ хэлье.

С.Ганбаатар: Парламент гэдэг анх парле гэдэг энэ франц үгнээс гаралтай л даа. Эсрэг тэсрэг байр сууриа ажил хэрэгчээр мэтгэлцэнэ, ярилцана, хэлэлцэнэ л гэсэн үг. Энэ асуудлыг улам сайжруулах гэж. асуудлыг гарц гаргалгаатай ярихаар эсэргүүцэж байна гэж ойлгодог. Үгүй шүү дээ. Цөмийн энергийн тухай хуулийг Цөмийн энергийн байх гэж л хичээж байгаа. Түрүүн Ундраа гишүүн зөв хэлж байна. Цөмийн, би ашигт малтмалын тухай хууль бол их муу хууль. Цөмийн энергийн тухай хуульд дэмжмээр олон заалтууд байдаг. Түүний нэг нь энэ 5.2, 5.3 буюу парламент

дээрээ 51 хувь, 34 хувиа баталгаажуулж өгсөн юмыг л бид мулталж, тэр Цөмийн энергийн комисс гэдэг улсуудад л эрх мэдлээ өгч байгаа, буулгаж байгаа гэсэн үг. Үгүй, нэг 10 дугаар ангийн хүүхэд 1 дүгээр ангийн хүүхэдтэй наймаа хийхдээ дараа нь аав, ээж чинь олон 7 юм ярихгүй биз л гэдгийг баталгаажуулж байна шүү дээ.

Тэгэхээр миний 1 дүгээр ярих зүйл гэвэл түрүүн Номтойбаяр гишүүн зөв хэлж байна. Одоо үүний араас тогтоол гарах ёстой, Их Хурлын тогтоол гарч нарийвчилж заахгүй бол ганцхан Цөмийн энергийн комисст бид нар бүх хувь заяагаа даатгана гэж байхгүй. Түүн дээр түрүүн ажлын хэсгээс нэг сонин юм яриад явчихлаа. Хэн нь хэлчхэв. Аюултай хог хаягдал байхгүй шүү дээ гэх юм. Үгүй энэ чинь цацрагт идэвхт ашигт малтмалын тухай ярьж байгаа шүү дээ. Цацрагт идэвхтэй, энэ аюултай, аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэрийг заавал энэ эрх зүйн орчныг нь бүрдүүлэх ёстой. Хөрөнгө оруулаад ашиг хийж байгаа бол заавал тэр барих ёстой. Энэ эрх зүйн орчноо хаана байна л гэж би асууж байгаа.

2 дугаар зүйл гэвэл, 34 хувиа бид нар өнөөдөр баталгаажуулчихсан мөртөө одоо буулгаад алдаж байгаа. Тэгвэл бага оврын реактортой цөмийн эрчим хүч боловсруулах нэг сайхан нартай өдөр болоход уранаа бид гуйхад, гуйлгачин шиг бид болно. Бид тодорхой хэмжээгээр 34 хувийн эрх мэдлээсээ бид салж байгаа хууль баталж байгаа.

3 дугаар зүйл гэвэл, хүхрийн хүчил. Одоо энэ 5 зэсийн төсөл явж байгаа. Монголын үндэсний үйлдвэрлэгч. Ер нь бол Ашигт малтмалын тухай хууль нарийн яривал гаднынханд долигоносон, үндэсний үйлдвэрлэгчдээ дээрэлхсэн л хууль байдаг юм шүү дээ, одоо удахгүй орж ирж өөрчлөгдөх юм гэнэ лээ. Тэгвэл үндэсний үйлдвэрлэгчид зэсээ хайлаад эхэлбэл хүхрийн хүчлийг нь яах вэ гэдэг шийдэл энэ дотор хамт яваа юм шүү. Үүнийгээ эрх зүйн орчныг нь ярихгүй, оруулахгүй явна гэдэг бол Монголын парламент сохорчихсон байна гэсэн үг.

Тэгэхээр Казахстаны Ерөнхийлөгч Токаев бас ухаантай юм. Ерөөсөө үнэ ярихгүй байгаа юм шүү дээ. Ураны үнэ тэд, мэд. 2000 тонн бол 4 хувийн роялти, 4000 тонн бол 6 хувийн роялти, 6 мянгаас дээш бол 8-аас дээш роялти авна гэж хэмжээнд нь тааруулсан. Энэ үнэтэй зүйл биш. Энэ маш ховрын зүйл. Картын бараа шиг зүйл. Энэ эрх мэдлээсээ салж байгаа хууль бид батлуулж байгаа. Би түрүүнээс хойш эсэргүүцээгүй шүү дээ, улам сайжруулмаар байна, улам цөмийн эрчим хүчтэй болмоор байна. Ногоон, хямд эрчим хүчтэй болмоор байна гэдэг мөрөөдлөөсөө Монгол орон салмааргүй байна.

Эцэст нь хэлэхэд одоо нэг 2 яс салж байх шиг байна. Хоёр 7 хоног л ярилаа. Ахан дүүс ээ, Цөмийн энергийн тухай хууль гэдэг нэрээ өөрчлөөд, Шар нутгийн тухай хууль гэж нэрлэвэл их зохилтой. Бүр яваандаа ямар ч аюул байхгүй. Шар бялууны тухай хууль гэж ярих гээд байх шиг байна. Стратегийн орд, стратеги гэдгээсээ ураныг хасчих. 34 хувиасаа татгалзана гэдэг бол эрх мэдлээсээ, шийдвэр гаргалтаасаа бид татгалзаж байгаа гэсэн үг шүү. Стратеги гэдэг бол эрх мэдэл, шийдвэр гаргах явдал юм байгаа юм. Ийм 2 зүйл дээр бид ноцтой өөрчлөлт оруулж байгаа хуулийг хүчиндээд баталж байна.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн үг хэлнэ.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ чинь 3 Ганбаатар биш, 4 Ганбаатар байгаа шүү. Манайхан мэдэж байгаа байх.

Ураны баяжмалын экспортоосоо НӨАТ авах юм уу, үгүй юү гээд би энэ хэлэлцүүлгийн явцад асуугаад хариултаа авч чадахгүй байгаа юм. Тэгэхээр энэ би дэмжиж байгаа. Гэхдээ үүнийг тэр ажлын хэсэг энэ тэр зөвлөмж гаргана гээд сая Номтойбаяр гишүүн хэллээ. Түүн дээрээ анхаарна биз дээ. Энэ эцсийн бүтээгдэхүүн бол биш шүү дээ. Ундраа гишүүн энэ тэр гээд энэ талаар мэргэшсэн хүмүүс мэдэж байгаа байх. Энэ эцсийн бүтээгдэхүүн бол биш.

Тийм учраас нэмэгдсэн өртгийн албан татвараа авах хэрэгтэй байх. Татвараа тултал нь авна гээд хариулаад байгаа юм. Тэгээд нэмэгдсэн өртгийн албан татвар чинь том татвар шүү. Тэгэхээр нэмэгдсэн өртгийн албан татвар чинь энэ дээр яг өнөөдрийн байдлаар бол энэ ураны баяжмал бол эцсийн бүтээгдэхүүний жагсаалтад орчихсон. НӨАТ-аас чөлөөлөгдчихсөн байгаа. Үүнийгээ засаач ээ гэдгийг байнга хэлж байгаа гэдгийг хэлье. Үүнийг би сая би асуултад яасангүй, энэ Уул уурхайн яам Туваан сайд үүнийг анхаарч байгаа байлгүй дээ.

Нөгөө талд нь энэ орон нутгийн харилцаан дээр Туваан сайд сайн ойлгож байгаа байх, сайн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Энэ 10 лиценз байна уу, хэдэн лиценз байна. Тэгэхгүй зүгээр хаячих юм бол ер нь, ер нь бүтэхгүй юм байна лээ шүү дээ тийм ээ. Тэгэхээр үүнийг ер нь яам, Их Хурал, Засгийн газар, хөрөнгө оруулагч талд нь ер нь сайн тийм зохицуулалт нэлээн сайн хийхгүй бол яг өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа хууль бол орон нутгийн харилцаа байхгүй шүү. Энэ Цөмийн энергийн тухай хуульд орон нутгийн харилцаа бараг байхгүй, бараг хамгаалахгүй гэсэн үг. Манай энэ ажлын хэсгийнхэн бүгд мэдэж байгаа байх. Харин Ашигт малтмалын хууль чинь харин зохицуулалттай, хамгаалалттай шүү. Тэгээд сая яах вэ, зүгээр Ашигт малтмалын хууль Туваан сайд ярилаа. Тэгээд ашигт малтмалын хууль дээр нэлээн том баг бараг 2 жил гаруй ажилласан. Өргөн барихдаа баг нэлээн өөрчлөгдөж байх шиг байна лээ. Уул уурхай яам. Тэгэхээр тэрийгээ нэлээн сайн өөрийн болгож байгаад, нэлээн тийм нухацтай хандах биз, хандана биз дээ. Түүн дээр тэгж байгаад өргөн барьсан нь зөв байх гэж би бодож байна. Цаг үе ч өөрчлөгдчихлөө. Бараг тэрнээс чинь хойш 2, 3 жил болчихлоо. Тэгэхээр тэрийгээ нэлээн сайн нухацтай хараарай. Тэгээд нэмэгдсэн өртгийн албан татвар дээр энэ бол нэг Монголын яг энэ бусад компаниудад их сонин үлгэр дуурайлал болчихдог юм шүү. Бусад нь бүгд барьцана шүү. Эцсийн бүтээгдэхүүн биш. Нэмэгдсэн өртгийн албан татвар чөлөөлөгдлөө. Бид бүгдээрээ нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөнө өө л гэнэ. Тэгээд энэ Сангийн яам тодорхой хариулдаггүй юм байна лээ л дээ. Уул нь одоо ийм сул мөнгөнийхөө араас явж баймаар юм. Тэгээд тэр би яах вэ, ажлын хэсгийн явцад зарчмын зөрөөтэй санал гаргая гэсэн, энэ хэн Пүрэвдорж дарга хөндөгдөөгүй санал гээд авахгүй байна лээ л дээ. Тэгэхээр үүнийгээ анхаарна биз дээ. Тэгээд Засгийн газарт боломж байгаа. Үг хэлж дууслаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дуламын Бум-Очир гишүүн үг хэлнэ.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Би нэг хуулийн заалт уншиж танилцуулъя. Соёлын биет бус өвийг таньж тогтоох судалгаа шинжилгээг өмчийн бүх хэлбэрийн эрдэм шинжилгээний лабораторид хийнэ гэж байгаа юм. Энэ бол соёлын өвийн тухай Соёлын өвийг хамгаалах тухай хууль. 27.8 дээр нь хот, суурин барилга, байгууламж барих, шинээр зам тавих, УЦС байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны зүйн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулна гэсэн байгаа. Энэ тухай асуултыг бүлэг дээр танилцуулж

байхад асуусан. Компани маань энэ судалгааг хийлгээгүй байгаа юм байна гэж би ойлгосон. Үүнийгээ хийлгээрэй гэдгийг би протоколд тэмдэглүүлмээр байна. Тэмдэглүүлмээр байна. Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх соёлын судалгааг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна гэж байгаа юм, 27.9. Үүнийгээ тэр төсөв зардал дээрээ суулгаарай гэдгийг онцлон хэлмээр байна.

Яг энэ заалтыг мөн Ашигт малтмалын тухай хууль дээр мөн оруулчихсан байгаа. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон зүйл заалтыг биелүүлнэ гэсэн ийм заалтууд байгаа. Тэгэхээр уул нь зүй нь байгаль орчны үнэлгээ хийлгэж орж ирсэн. Яг энэтэйгээ хамт энэ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн заалтуудаа биелүүлээд, судалгаагаа хийлгээд, дүгнэлт шинжилгээг нь аваад ороод ирсэн байх учиртай. Үүнийгээ та бүхэн маань цаг алдалгүй хийгээрэй. Би хийх байх гэж найдаж байна. Тэгэхгүй бол нэгд, энэ хууль биелүүлээгүй юм шиг харагдана. 2-т, энэ Монголчууд бидний үнэт зүйл болсон энэ түүх соёлын дурсгалт зүйлд хүндэтгэлгүй хандаж байгаа юм шиг харагдах вий. Би хүндэтгэлгүй хандаж байгаа гэж бодохгүй байна. Гэхдээ энийгээ хийхгүй бол тэр зүг рүү явчихна шүү. Үүний чинь араас нөгөө нэг бослого хөдөлгөөн гэдэг элдэв юм чинь гардаг шүү.

Тэгэхээр энэ юмнуудаа сайн хийгээрэй. Тэр нөлөөллийн болоод шууд болоод шууд бус нөлөөллийн бүсэд нь археологийн энэ тэр палеонтологийн олдвор энэ тэр юмнууд байгаа юм уу, байхгүй юм уу? Үүнийг бид мэдэх ёстой. Хэрвээ байгаа бол түүнийгээ яаж хамгаалах ёстой юм, яаж хадгалах ёстой юм. Яаж авран хамгаалах ёстой юм бэ гэдэг энэ төлөвлөгөө чинь уул нь гарчихсан байж байх ёстой шүү. Үүнийгээ хийгээрэй гэдгийг та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна. Хийх болов уу гэж бодож байна.

Түүнчлэн энэ чиглэлээр хяналт тавьж ажилладаг төрийн байгууллагууд энэ хяналтаа сайжруулмаар байна. Ер нь нэг ийм зүйл байгаад байдаг. Энэ уул уурхайн компаниуд болоод олон компаниуд байгаль орчны үнэлгээгээ хийчихдэг. Энэ түүх соёлын судалгаа болоод үүнтэй холбогдох үнэлгээгээ хийдэггүй. Нэг ийм зүйл байдаг. Мэддэггүй байдаг юм уу. 21 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуульд орж ирсэн, харьцангуй хожуу орж ирсэн учраас мэдэхгүй байхыг үгүйсгэхгүй. Тийм учраас би бусад бүтээн байгуулалт хийж байгаа уул уурхайн компаниуд болоод бусад компаниуд энэ хуулийн заалтыг биелүүлж, түүх соёлдоо хүндэтгэлтэй хандаж байхыг уриалж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн үг хэлнэ.

Г.Ганбаатар: Энэ хуулийн өөрчлөлт яах вэ, ингээд явчих байх. Удахгүй Хөрөнгө оруулалтын тухай хууль орж ирэх байх. Бид нар энэ хууль дээр л их чамбай хандах ёстой л доо. Нийт гишүүдийн болгоомжлол ч гэсэн тэр тал руугаа байх шиг байна. Оюутолгойн гэрээ шиг л 35 жилийн дараа ашгаа хүртдэг болчих вий гэдэг болгоомжлол хаа сайгүй л байх шиг байна.

Энэ хуулийн төсөлтэй холбоотой гэхээсээ илүү ер нь яах вэ, энэ хууль явсны дараа хамгийн түрүүнд төсөл хэрэгжүүлэх бүс нутаг чинь манай Дорноговь аймаг. Ялангуяа энэ Бадрах Энержи төсөл хэрэгжих чинь энэ Улаан бадрах Зөөвч -Овоо чинь яг Зүүнбаянгийн Улаан бадрахын зааг нутаг шүү дээ. Тэгээд үүнтэй холбоотой орон нутгийн жаргал, зовлон мэдэх хүний хувьд бол 2 саналыг хэлье л гэж бодоод

байгаа юм. Хуулийн төсөлтэй гэхээсээ илүү энэ хууль батлагдаад цаашдаа энэ цөмийн энергийн төслүүд хэрэгжих гол бүс нутаг чинь манай Дорноговь аймаг.

Тэгээд энэ Дорноговь аймгийн баруун урд сумд энэ төсөл хэрэгжих бүс нутгийнхаа хүн болон малын эрүүл мэндийн чиглэлийн судалгааг нэг төсөл эхлэхээсээ өмнө нэг дахин нэг хийгээдхээрэй. Орон нутагт байгаа бид нарт үнэхээрийн хүндрэл учруулдаг шүү. Тухайн бүс нутагт байгаа хүн болон малд цацраг идэвхийн нөлөөлөл байна уу гэдэг дээр байнгын ийм тандалт хийдэг мониторингийн систем бий болгоорой гэж нэг хүсэх байна.

2 дахь нь энэ хэл ам, хар сэр даруу дагуулаад байгаа гол асуудал чинь ураны олборлолт. Ялангуяа энэ газар доор уусган олборлох арга чинь. Үүнийгээ нэг шинжлэх ухааны үндэстэй ард иргэдэд маш энгийнээр ойлгуулах тийм контентуудыг хийгээч гэж хүсэх байна. Ер нь цаашдаа ч гэсэн энэ Цөмийн энергийн хуулийн өөрчлөлт орж байгаатай холбоод үүнтэй холбоотой олон гадаадын хөрөнгө оруулагчид бид татварын орчин бусад орчныг сайжруулж өгөх гэж байна, орж ирэх байх. Тэгээд энэ нэг ард иргэдэд ийм энгийнээр ойлголт төрүүлэхгүй бол хүн чинь ер нь нөгөө мэдэхгүй юмныхаа дайсан гэгчээр ташаа ойлголт төрчихсөн хүн чинь тэгээд 1 тэр залруулга хийтлээ л их л уддаг л юм байна л даа. Тэгээд одоо хаанаас ч гараад байгаа энэ хуучин нөгөө Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын үеийн Зүүн Германы нөгөө Вейс Мутад олборлож байсан нэг кинонууд л Үндэсний телевизээр тухайн цаг үедээ гарч байсан бололтой юм. Үүнийг л хаа сайгүй л энэ сошиал орчинд явуулаад байх юм. Тэр чинь бол энэ олборлох арга нь шал өөр шүү дээ. Тэгээд ийм аюултай юм байна гэсэн ойлголт иргэдэд төрчихлөө. Тэгээд энэ чиглэлээр ер нь энэ хууль боловсруулагчид, ажлын хэсэг энэ дээр сайн анхаараарай гэдгийг хэлэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хураалт. 1 санал байгаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томьёолол.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсгийн “энэ хуулийн 34.6-д заасан журмын дагуу тооцож, төрийн дансанд байршуулна.” гэснийг “олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэл ашиглах, эс үгүй бол Монголбанк дахь валютын тусгай санд байршуулах бөгөөд гагцхүү зориулалтын дагуу ашиглана.” гэж өөрчлөх. Санал гаргасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Энэ зарчмын зөрөөтэй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

61 гишүүн дэмжиж, 65,6 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор. Дэмжсэн гишүүдийн тоонд Пунсалмаа гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Ундраа гишүүн, Мэндсайхан гишүүн нар, Тэмүүлэн гишүүн нар дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Ингээд зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё.

Тэмүүлэн гишүүн горимын санал уу? Горимын санал.

Г.Тэмүүлэн: Өглөөний мэнд. Их Хурлын дарга аа, нөгөө Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар эцсийн хэлэлцүүлэгт эцэслэсэн учраас эцэслэн батлах бас нэг саналтай байна. Тэгэхээр манай Байнгын хороонд чиглэл өгөөч. Өнөөдрийн хуралдаанд нэгдсэн хуралдаанд оруулж, эцэслэн баталъя гэсэн саналтай байна.

Д.Амарбаясгалан: Байнгын хороо бэлдэж амжих уу тийм ээ. Яах вэ, эцэслэн батлахыг бол хурал даргалагчийн зүгээс урьдчилан цаг хэлж, санал хураалгах боломжтой. Тэгвэл Байнгын хороо бэлтгэж амжина гэвэл өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлах уу? Гишүүд дэмжиж байна уу?

Тэгвэл энэ дараагийн асуудал хэлэлцэж байх хооронд Байнгын хороо бэлтгэл хангачих. Тэгээд түүний араас оруулаад өнөөдрийн хэлэлцэх асуудлын тов дараалалд нэмээд, тэгээд санал хураалтыг явуулъя, эцэслэн баталъя аа, оруулчихъя, тэгье. Даргын зөвлөлийн хурлаас санал аваад оруулчихъя.

14.19 цаг

Дараагийн асуудалд оръё.

“Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянга хишиг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр бүх Монгол Улсыг, үүнээс хойш Бүгд Найрамдах бүрэн эрхт Ард улс хэмээж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эдлүүлэн, улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүслэн дагавал зохино гэж Бүгд Найрамдах Улсыг тунхаглан анхдугаар Үндсэн хуулиа баталсны 100 жилийн ой энэ жил тохиож байна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж “Анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” 64 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд Улсын Их Хурлын даргын 2024 оны 117 дугаар захирамжаар тогтоолын хэрэгжилтийг хангах, ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсэг олон арга хэмжээ зохион байгуулж байгаагийн нэг нь Үндсэн хуулиа эрхэмлэн дээдлэх үзэл санааг иргэдэд тайлбарлан таниулах үйл ажиллагаа. Энэ хүрээнд улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа, хүний эрх, эрх чөлөө, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн үндэс суурь болсон Үндсэн хуулийг

иргэн бүр судлан мэдэхийг уриалж, төрийн бүх байгууллагуудад дээдлэн залах, түүнчлэн Үндсэн хуулийн үзэл санааг бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийн агуулгад тусган хүүхэд, залуучуудад мэдлэг олгох, хэвлэл мэдээллийн байгууллагаар сурталчлан таниулах зорилгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасныг баримтлан 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар Үндсэн хуулийг тунхаглалын шинж чанартай бус Үндсэн хуулийн үзэл санааг бага наснаас нь ойлгуулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Үндсэн хуулийн үзэл санааг тайлбарлан таниулах агуулга боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт багтдаг эсэх, хэрхэн сайжруулах талаар хэвлэл мэдээллийн байгууллагад уриалах бус үүрэглүүлэх боломжийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, О.Алтангэрэл, Г.Уянгахишиг, Б.Батбаатар нар Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, суртчилан таниулахтай холбоотой “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Г.Уянгахишиг нар тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

“Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгөхийг хүсье. 2 гишүүнээр, 3 гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, асууя. Асуулт асууна.

С.Эрдэнэболд: Асуулт үг нь давхцаж байгаа биз дээ тийм ээ. Монгол Улсын Үндсэн хууль бол манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ардчиллын гол тулгын чулуу. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Бираагийн Чимэд гуай Үндсэн хуулийн эхийг баригч нэгэн цагт Үндсэн хууль бол алганд багтсан Монгол Улс гэж хэлж байсан байдаг. Үнэхээр сүүлийн үед гарч байгаа энэ манлайллын хомсдол, үзэл санааны хямрал, энэ бүх зүйл, нийгмийн оюун санааны энэ хоосрол энэ бүх зүйл бол Үндсэн хуульд ёсыг улаандаа гишгэсэн, тэр байтугай парламентын засаглалыг үл тоосон ийм популист үйл явдлуудаас эхтэй.

Тэгэхээр энэ нийгмийн оюун санааг шинэ түвшинд гаргах, Монгол Улсын оюун санааны тусгаар тогтнолыг авч үлдэх нэг том шалгуур бол энэ Үндсэн хуульт ёсоо эрхэмлэн дээдлэх, зөвхөн эрхэмлэн дээдэлж залаад зогсохгүй бас иргэд нь Үндсэн хуулиа сайн мэддэг байх, эрх мэдэлтэй албан тушаалтнууд нь Үндсэн хуулийн үзэл санаанд үнэнч зүтгэдэг байх, энэ зарчмаас эхэлнэ гэж үзэж байгаа.

Тэр 2024-2028 оны парламентын стратеги гэж баталсан байгаа. Энд бол энэ хүн төвтэй шалгуур үзүүлэлтийг оруулсан байгаа. Бид 32 жил гаруйн туршид энэ шинэ Үндсэн хуулийн үзэл санаандаа хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно гэж заасан хэр нь хүмүүнлэг буюу хүнлэг байдал, иргэний нийгмийнхээ үзэл санаанаас олон удаа буцаж ирсэн. Үүн дээрээ тууштай зогсоогүй, маш олон удаагийн улс төржилт, сонгуулийн амлалт, өнгө мөнгөтэй холбоотой шийдвэр гаргалтууд нь Үндсэн хуулийг уландаа гишгэсэн ийм үйлдлээс эхтэй.

Тийм учраас энэ зүгээр бол нэг Улсын Их Хурлын тогтоол, Үндсэн хуулийг судар шиг, тавилга шиг залах тухай асуудал биш. Цаагуураа энэ Үндсэн хуулийн, анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ойд зориулж, Монгол Улс Үндсэн хуульт ёсондоо, парламентын засаглалтай, хүний эрх, эрх чөлөөндөө тууштай, туйлбартайгаар зогсож чаддаг байх тухай ийм шийдвэр гэж харж байгаа. Тийм учраас энэхүү тогтоолыг дэмжиж байгаа.

Ялангуяа энэ цаг үеийн ороо бусгаа үе, дээрээс нь хөрш орнуудын цэрэг, эдийн засгийн төвөгтэй байдал, сүүлийн жилүүдэд дэлхий дахинд гарч байгаа хүний эрхийн томоохон сорилт, бэрхшээлүүд, үзэл санааны сорилт бэрхшээлүүд, нацизм, дээрээс нь популизм, хэт үндсэрхэг үзэл ингэж гаарч байгаа энэ нөхцөл байдалд нийгмийн оюун санааны шударга ёсны амьд халуун дархлаа болсон парламентын засаглал Үндсэн хуульт ёсыг Монгол Улс цаг ямагт баримталж, шийдвэр гаргах, бодлого боловсруулах бүх шатдаа үүнийг сурталчлан танин мэдүүлдэг байх. Дээрээс нь парламентын гишүүд нь ч гэсэн өөрсдөө үүн дээр үзэл санааны манлайлагчид байх, үг үйлдлээрээ шийдвэр гаргалтаараа, бас манлайлагч байх ийм хариуцлагатай түүхэн цаг ирсэн гэж үзэж байгаа.

Тийм учраас өнөөдрийн гаргах гэж байгаа энэхүү тогтоолыг бүрнээ дэмжиж байгаа юм. Үндсэн хуулиа дээдэлнэ гэдэг бол, Үндсэн хуулиа дэлгэрүүлнэ гэдэг бол Үндсэн хуульт ёсыг хамгаална гэдэг бол парламентын засаглал, ардчилал энэ бүх үнэт зүйлийнхээ төлөө хийж байгаа алхам гэж үзэж байгаа.

Тэгэхээр өнөөдрийн тогтоолыг манай парламентын гишүүд 100 хувийн саналаар, өндөр ирцтэйгээр дэмжээсэй гэж уриалж байна. Та бүхэнд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Батбаатар: Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, дээдлэн сахих, Үндсэн хуульт улс орон гэдгээ ойлгон мэдэх энэ чиглэлийн ажил хийхийг Улсын Их Хурлаас тогтоол гаргахыг дэмжиж байгаа.

Харамсалтай нь Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ жаахан харамсана. Хэмжих нэгж, орон зай, цаг хугацаа, гүйцэтгэл, хяналт тавигдах аргагүй уламжлалт тогтоолыг тунхгийн шинж чанартай Улсын Их Хурал дахин батлан гаргах гэж байна. Ийм тогтоол нөгөө гүйцэтгэл нь харагддаггүй, хэрэгжилт нь харагддаггүй, бид тогтоол гаргасан шүү дээ гэдэг үгээр хаадаг. Ийм тогтоол гаргамааргүй байгаа

юм. Бид нар социализмын үед 90 оноос өмнө номыг тавилга болгосон олон айл өрх, олон хүмүүс байсан. Яг түүнтэйгээ адилхан бид нар Чингис хаанаа тавилга болгосон. Үндсэн хууль Монголын нууц товчоогоор тавилга болгосон. Ийм тавилга болгодог Үндсэн хуулийг нэг шоголтой, баринтагтай, залсан ном болгодог ийм зүйл болгож болохгүй. Үндсэн хуулийн үзэл санааг иргэн болгон мэдэж, ойлгож, ухамсарлаж, Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө мэддэг байх нь Монгол төр зөв байхад хэрэгтэй байна.

Дээр нь Үндсэн хуулийг таниулан мэдэх, Үндсэн хуулийн үзэл санааг дархлаажуулах нь засаглалыг солихгүй байх бас нэг үндэс суурь. Парламентын ардчилсан засаглалтай байх бол бид нарын Үндсэн хуульдаа зааж тогтоосон нийгмийн суурь гэрээ. Тийм болохоор энэхүү тогтоолыг сайжруулж, илүү ойлгомжтой, илүү хүртээмжтэй, илүү өргөн, олон нийт, иргэдээрээ Үндсэн хуулиа мэддэг байлгахын тулд, сайжруулахын тулд Төрийн байгуулалтын байнгын хороо руу дахин хэлэлцүүлэх нь, хэлэлцүүлэхээр буцаах нь зүйтэй байх.

Төрийн байгуулалтын байнгын хороо дээр 4 зарчмын зөрөөтэй санал оруулсан. Дэмжиж өгөөгүй. Тэгэхдээ яах вэ, тэр нь Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийн асуудал учраас хэлэх үг байхгүй. Тийм болохоор үзэл санааг нь дэмжиж байгаа боловч сайжруулах буюу эргэж гарт баригдах, нүдэнд харагдах, үнэхээр иргэдэд энэ Үндсэн хууль гэдэг зүйл чинь ийм юм байдаг юм байна, үүнийг ойлгох хэрэгтэй юм байна, Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнийхээ хувьд би ийм эрхтэй юм байна, манай засаглал ийм байна гэдэг энэ тогтвортой байдлыг хангахын тулд энэ тогтоолыг нэг удаа буцааж өгөхийг хүсэж, гишүүдээс татгалзсан санал өгнө үү гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгөх ажлын хэсгийн, Төрийн байгуулалтын байнгын хороо санаачилсан. Тийм. 1 дэх өдөр, 2 дахь өдөр Үндсэн хууль, Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ой болно. Хүндэтгэлийн чуулган хуралдахаар байгаа, тийм. Тэгэхээр энэ дээр Батбаатар гишүүний хэлсэн үгэнд хариулт өгөх хүн одоохондоо алга.

Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн үг хэлнэ. Уянгахишиг гишүүн үг хариулт өгөх байсан уу? хариулт өгөх үү? Уянгахишиг гишүүн хариулт өгье.

Г.Уянгахишиг: Төрийн байгуулалтын байнгын хороо дээр яг энэ тогтоолынхоо төслийг хэлэлцээд, Батбаатар гишүүн бид 2 зарчмын зөрөөтэй саналууд гаргаад, ерөнхийдөө олонхоороо дэмжигдээгүй. Гэхдээ тухайн одоо энэ тогтоол ерөнхий байдлаар гарч байгаа буюу Батбаатар гишүүний гаргаж байсан саналууд буюу нарийвчилсан байдлаар цахим боломжийг ашиглах ч гэдэг юм уу, тийм ээ, буцаагаад контентууд гэдэг талаасаа ч гэдэг юм уу, энэ бол өөрөө тухайлан тухайн хариуцсан нэгжүүдийн цаашаа хийгээд явах боломжтой ийм ажлууд байгаа учраас яг энэ Их Хурлын тогтоол дээр нарийвчилж тусгах нь тийм зүйтэй биш юм байна гэдгээр Байнгын хорооны санал, дүгнэлт гарчихсан учраас үүнийгээ цаашаа хэлэлцүүлээд явбал зөв байх гэдэг саналтай байна.

Д.Амарбаясгалан: Тэгээд хэрэгжүүлэх төлөвлөгөөг мэдээж цааш нь хэрэгжүүлэхдээ анхаарал хандуулах, эдийн засгийн хэмнэлттэй, нүсэр хэмжээний ажил зохион байгуулахгүйгээр энэ Үндсэн хуулийнхаа утга санааг, агуулгыг ойлгуулдаг хэлбэр лүүгээ л бид анхаарах нь зөв юм байгаа юм. Түүнээс яг хэрэгжүүлэхтэй холбоотой энэ деталь асуудлуудыг энэ хэрэгжүүлэх Засгийн газар

болон холбогдох байгууллагуудад энэ протоколд тэмдэглэснээр үүрэг чиглэл болгож өгөх нь зөв байх гэж ингэж бодож байна.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг ...

Больё гэсэн, Лодойсамбуу гишүүн үг хэлэхээ больё гэсэн.

Одоо Байнгын хорооны саналаар “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулахаар байгаа. Гишүүдийг танхимд орж ирэхийг урьж байна. Гишүүд суудлаа эзэлье. Гишүүд танхимдаа цугларъя. Санал хураалт явагдана.

Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэнгийн гаргасан горимын саналын дагуу Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг эцэслэн батлах асуудлыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дэмжээд, өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов дараалалд орсон байна.

Тэгэхээр энэ санал хураалтын араас Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах нь байна. Эцэслэн батална гэдэг бол та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Нийт гишүүдийн олонх буюу 64 гишүүнээр хууль эцэслэн батлагддаг байгаа. Тэгэхээр бүлгийн дарга нар, бүлгийн гишүүд танхимдаа цугларахыг хүсэж байна.

Бүгдээрээ нэг ирц бүртгэлийн санал хураалт явуулаадах уу? Танхимд хэдэн гишүүн байна вэ? Ирц бүртгэлийн нэг санал хураалт явуулъя. Санал хураалт.

Би сая алдаа гаргачихлаа. Ингээд 58 гишүүн, 59 гишүүн ирцэд бүртгэлтэй байгаа юм байна. Нийт бүртгэлтэй 93 гишүүн, түүнээс танхимд 59 гишүүн байгаа юм байна.

Ингээд Байнгын хорооны саналаар “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Байз, миний төхөөрөмж алдаатай болоод болдоггүй дээ. Нийт гишүүд 61 гишүүн дэмжсэнээр 65,6 хувиар санал дэмжигдлээ.

Миний төхөөрөмж дээр алдаа гарсан учраас би дэмжсэн саналд орж байгаа, протоколд тэмдэглүүлье. Батжаргал гишүүн байна, дэмжсэнээр. Туваан гишүүн нарыг нэмж протоколд тэмдэглэе. Нийт гишүүдийн 65,6 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Ингээд тогтоолын төсөл батлагдсан. Тогтоолын төслийг би уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Үндсэн хуулиа дээдлэн залах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Бүгд Найрамдах Улсын үндсэн тулгуурыг тогтоон, Үндсэн хууль тусгаар улсыг тунхаглан зарласан Анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ач холбогдлыг тэмдэглэж, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталсан ардчилсан шинэ Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, нийт байгууллага, иргэний үйл ажиллагааг Үндсэн хуульд бүрнээ нийцүүлэх, мэдэгтүн, сахигтун гэж даяар олноо зарлан тунхагласныг сахин биелүүлэх зорилгын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тогтоосугай.

1. Төрийн бүх байгууллага, улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчдийн газар Үндсэн хуулиа дээдлэн залсугай.

2. Иргэн бүр Үндсэн хуулиа судлан мэдэж, айл өрх бүр Үндсэн хуулиа дээдлэн залахыг уриалсугай.

3. Үндсэн хуулийн агуулга, Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусган, түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулахыг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох бусад төрийн байгууллагад даалгасугай.

4. Үндсэн хуулийн агуулга, Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулах, сурталчлах хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай.

5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад даалгасугай.

6. Тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын эцсийн найруулга дээр. Тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Уянгахишиг гишүүн байна. Уянгахишиг гишүүний микрофон.

Г.Уянгахишиг: Тэгэхээр 2 дахь өдөр бид хүндэтгэлийн чуулгантай байгаа, 100 жилийнхээ ойг тэмдэглэх гэж байна. Тэгэхээр эцсийн найруулгыг өнөөдөр сонсох горимын саналыг гаргаж байна. Тогтоолын эцсийн найруулгыг биш ингээд дахиад эцсийн найруулга бэлдэнэ шүү дээ.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр үгүй ээ, энэ чинь бэлдэх юм байхгүй л дээ. Сая тийм, тараачихсан байгаа тийм ээ. Тэгэхээр Уянгахишиг гишүүний гаргасан горимын саналыг Улсын Их Хурлын гишүүд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Харин тийм, уул нь хураачихсан шүү дээ, тийм.

Тэгэхээр эцсийн найруулгыг сонссонд тооцъё, тийм ээ, Уянгахишиг гишүүний гаргаж байгаа саналаар. Тэгье. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өөр саналтай хүн алга байна.

11.40 цаг

“Монгол Улсын Их Хурлын 2024-өөс 28 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

“Монгол Улсын Их Хурлын 2024-өөс 28 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Хувилж тараагдсан байгаа. Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.41 цаг

Ингээд Байнгын хорооны даргын гаргасан горимын саналаар хэлэлцэх асуудлын тов дараалалд нэмэлтээр орсон Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлахаар байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д 7 хоногийн Баасан гарагийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу хуулийн төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бэлтгэж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалтыг явуулна.

Ирцээ сайжруулъя. Дахиад нэг ирцийн санал хураалтыг явуулъя. Ирц бүртгээдэхье. Эцэслэн батлах учраас бид гишүүдийнхээ ирцийг бүрэн хангалттай байлгаж байж, санал хураалт явуулах учиртай байгаа. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя.

Амарсайхан Шадар сайд бүртгэлдээ орсон уу? Нарантуяа-Нара 2 хүн сая бүртгэлд орж чадаагүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа.

Ингээд санал хураалтыг эхлүүлье.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт.

Нийт 70 гишүүн дэмжиж, 74,5 хувиар дэмжигдлээ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:

2. Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Энэ Цөмийн энергийн хууль өөрчлөлт орсонтой холбоотойгоор дараа нь Ронагийн гэрээ орж ирнэ. Тийм учраас нэг тодорхой энэ Их Хурлын гишүүдийн хэлэлцүүлэгтэй холбоотой нэг чиглэлийг ярья гэж бодож байна.

Тэгэхээр Цөмийн энергийн хуульд заасны дагуу Хөрөнгө оруулалтын гэрээгээр зөвхөн санхүү, хөрөнгө оруулалт, хөрөнгө болон татвартай холбоотой асуудлыг шийддэг. Тийм учраас энэ 2013 оны хувьцаа эзэмшигчдийн гэрээ, 2016 оны орд ашиглах гэрээндээ бусад асуудлаа Монголын эрх ашгийн төлөө сайн шийдээрэй гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарх нь бол давуу эрхийн хувьцааны дагуу төлөөлөн удирдах зөвлөлд орох Монголын талын гишүүдийн саналын эрх, хориг тавих эрх, хяналт шалгалт тавих тэр эрхүүдийг онцгойлон анхаарах шаардлагатай байна.

3 дугаарт нь бол, энэ хуулийн өөрчлөлтөөр байгаль орчин, устай холбоотой асуудлыг ерөөсөө шийдээгүй. Тийм учраас Засгийн газраас энэ байгаль орчин, устай холбоотой хууль, эрх зүйн өөрчлөлтийг яаралтай оруулж ирэх шаардлагатай байгаа.

4 дүгээрт нь, шар нунтаг бол эцсийн бүтээгдэхүүн мөн эсэх, түүнээс шалтгаалаад НӨАТ-ын буцаан олголтыг авах эсэх асуудлаар Засгийн газар энэ дээр нөгөө талтайгаа сайн ярилцаж, анхаарах хэрэгтэй байна.

5 дугаарт нь, уурхайн хаалтад зарцуулах хөрөнгийн санхүүгийн баталгаа, хөрөнгийг санхүүгийн баталгаа юм уу аль эсвэл Монголбанкны валютын дансанд байршуулах тухай асуудал байгаа. Тэгэхээр ялангуяа энэ Ронагийн гэрээн дээр энэ Монголбанканд байршуулах тэр заалтыг тусгаж, гэрээндээ оруулж ирээрэй гэсэн ийм чиглэлийг өгч байна.

Тэгээд 6-д нь бол, гишүүдийн их яриад байгаа өөрөөр хэлбэл цаашдаа бид нар энэ АЦС-тай болох ёстой. Зөвхөн шар нутгаас цаашаа баяжуулах шаардлагатай. Ийм учраас энэ мэргэжилтнүүдээ бэлтгэх асуудлыг ялангуяа энэ хөрөнгө оруулагч талтайгаа сайн ярилцаж, тэдний сайн туршлагыг авч ялангуяа Казахстаны туршлагыг дагаж, бид нар илүү сайн түвшинд, геополитикийн илүү сайн үр дүнд авчрах энэ ажил дээр мэргэжилтнүүдээ сайн бэлтгэж авах нь чухал байна гэдгийг хэлмээр байна.

Тэгээд үүний дагуу бид бүхэн цаашдаа яг энэ энэ Цөмийн энергийн хуульд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Батнайрамдал гишүүний гаргаад байгаа Улсын Их Хурлаас тогтоол гаргаж, яг энэ гэрээн дээр ийм ийм зүйлийг анхаарах ёстой гэдгийг ярилцана. Үүнийг даргын зөвлөл дээр ярилцаж байгаад, тогтоолоо оруулах уу, цаашдаа ямар байдлаар асуудлаа шийдэх вэ гэдгээ ярилцах болно гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 2 дахь санал хураалт дээр явж байгаа. Уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

64 гишүүн дэмжсэн.

Номинчимэг гишүүн, Энхтүвшин гишүүн, Батсуурь гишүүн, Мөнхбаясгалан гишүүн, Баясгалан гишүүн, 5 гишүүн дэмжсэнээр протоколд юм уу. Энэ 64 болчихоор чинь яах билээ, манай Тамгын газраас. Болчихно тийм ээ, тийм шүү дээ 64. Тийм, тийм болчхож байгаа.

5 гишүүн нэмэгдэж протоколд тэмдэглүүлж байна.

Яах вэ, 64 болчихоор хүчинтэй болчхож байгаа юм. Харин тийм. 64 болоод 63-аас дээшээ 64 болчхож байгаа учраас хүчинтэй болчхож байгаа юм. Дэмжигдсэн. Нэмээд 5 гишүүн протоколд тэмдэглүүлж байна гэсэн үг.

Гишүүд микрофонд хэлж болно. 5 гишүүн. Батсуурь гишүүн, Мөнхбаясгалан гишүүн. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. Сая энэ дээр нөгөө гацчихлаа, жаахан.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Хэлэх юм уу. Сая дэмжсэн санал өгсөн боловч төхөөрөмжийн үүднээс эсрэг гарсан байна. Дэмжсэн дээр тооцож өгнө үү?

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Дэмжиж санал өгсөн, төхөөрөмж ажилласангүй. Тэгээд дэмжсэнээр бүртгэж өгнө үү?

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Дэмжсэнээр санал өгсөн байгаа. Сая төхөөрөмж гацчихлаа. Дэмжсэнээр бүртгэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Ингээд санал дэмжигдлээ.

3. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

64 гишүүнээр санал дэмжигдлээ.

Би саналаа өгч амжсангүй, протоколд тэмдэглүүлье.

Батжаргал гишүүнд микрофон өгье. Алтаншагай гишүүнд микрофон өгье. Жигжидийн Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Саяын санал хураалтад дэмжиж санал өгсөн боловч техникийн тодорхой шалтгаанаас эсрэг санал гарч байна. Тийм учраас дэмжсэнээр протоколд тусгаж өгөхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Алтаншагай гишүүний микрофоныг өгье. Алтаншагай гишүүний микрофоныг өгье.

Н.Алтаншагай: Дэмжиж санал өгсөн, төхөөрөмж болсонгүй.

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Би дэмжиж санал өгсөн боловч энэ төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр дэмжсэнээр бүртгэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Дэмжсэнээр тооцож өгнө үү.

Д.Амарбаясгалан: Ингээд санал дэмжигдлээ.

4. Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

64 гишүүн дэмжиж, 68,1 хувиар санал дэмжигдлээ.

Үүрийнтуяа гишүүн, Энхтүвшин гишүүн 2-т микрофон өгье. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Саналыг дэмжсэнээр авч өгнө үү. Санал орсонгүй.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүний микрофон өгье.

Д.Энхтүвшин: Саналыг дэмжсэнээр оруулж өгнө үү. Төхөөрөмж ажилласангүй.

Д.Амарбаясгалан: Эрдэнэбүрэн сайдын микрофоныг өгье. Эрдэнэбүрэн сайдын микрофоныг өгье.

Р.Эрдэнэбүрэн: Төхөөрөмж ажилласангүй, дэмжсэнээр саналаа өгнө.

Д.Амарбаясгалан: Ингээд 4 дэх асуудал дэмжигдсэн байгаа.

Ингээд хуулийн төслүүд батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд талархал дэвшүүлье.

Номтойбаяр гишүүн уг санал хураалтуудыг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлж өгөөч гэж байна. Доржханд сайд 2.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байна.

Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

13 цагаас даргын дэргэдэх зөвлөл Нийгмийн даатгалын багц хуулиудын асуудлаар танилцуулга сонсохоор байгаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ